

**АЮУЛГҮЙ БАЙДАЛ, ГАДААД БОДЛОГЫН
БАЙНГЫН ХОРООНЫ ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛИЙН АГУУЛГА**
2024 оны 01 дүгээр сарын 10-ны өдөр, Лхагва гараг

Хуралдааны тэмдэглэлийн агуулга

Хуралдааны товч тэмдэглэл: 1-5

Хуралдааны дэлгэрэнгүй тэмдэглэл: 6-35

1. “Онцгой байдлын ерөнхий газарт гал унтраах тусгай зориулалтын машин нийлүүлэх төсөл”-ийг хэрэгжүүлэх Монгол Улсын Засгийн газар, Бүгд Найрамдах Франц Улсын Засгийн газар хоорондын Санхүүгийн хэлэлцээрийг соёрхон батлах тухай хуулийн төсөл /Засгийн газар 2023.12.20-ны өдөр өргөн мэдүүлсэн, соёрхон батлах/	7-13
2. “Онцгой байдлын ерөнхий газрын агаараас аврах ангид нэмэлт сургалт явуулах төсөл”-ийг хэрэгжүүлэх Монгол Улсын Засгийн газар, Бүгд Найрамдах Франц Улсын Засгийн газар хоорондын Санхүүгийн хэлэлцээрийг соёрхон батлах тухай хуулийн төсөл /Засгийн газар 2023.12.20-ны өдөр өргөн мэдүүлсэн, соёрхон батлах/	13-16
3. Байнгын хорооны тогтоолын төсөл /Улсын Их Хурлын 2023 оны намрын ээлжит чуулганы 2024 оны 01 дүгээр сард Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хорооны хэлэлцэх асуудлын цаглавар батлах тухай/	16-17
4. Элчин сайд нарыг эгүүлэн татах, томилох асуудлаар зөвшилцөх тухай /Монгол Улсын Ерөнхийлөгчөөс 2024.01.09-ний өдөр өргөн мэдүүлсэн, зөвшилцөх/	17-31
5. “Бүгд Найрамдах Узбекистан Улсын нийслэл Ташкент хотод Монгол Улсын элчин сайдын яам нээн ажиллуулах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл /Засгийн газар 2024.01.08-ны өдөр өргөн мэдүүлсэн, зөвшилцөх/	31-35

**Монгол Улсын Их Хурлын 2023 оны намрын ээлжит чуулганы
Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хорооны
2024 оны 01 дүгээр сарын 10-ны өдөр /Лхагва гараг/-ийн
хуралдааны товч тэмдэглэл**

Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хорооны дарга Б.Энх-Амгалан ирц, хэлэлцэх асуудлын дарааллыг танилцуулж, хуралдааныг даргалав.

Хуралдаанд ирвэл зохих 17 гишүүнээс 9 гишүүн хүрэлцэн ирж, 52.9 хувийн ирцтэйгээр хуралдаан 09 цаг 59 минутад Төрийн ордны “Их эзэн Чингис хаан” танхимд эхлэв.

Чөлөөтэй: Н.Алтанхуяг, Э.Бат-Амгалан, С.Батболд, Ж.Эрдэнэбат.

“Зэвсэгт хүчний зэвсэг, техникийг шинэчлэх, сэргээн сайжруулах бодлогыг батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийн анхны хэлэлцүүлгийг Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.2-т заасны дагуу хаалттай горимоор хэлэлцэв./10:03/

Хуралдаан 11 цаг 00 минутаас нээлттэй горимд шилжив.

Нэг. “Онцгой байдлын ерөнхий газарт гал унтраах тусгай зориулалтын машин нийлүүлэх төсөл”-ийг хэрэгжүүлэх Монгол Улсын Засгийн газар, Бүгд Найрамдах Франц Улсын Засгийн газар хоорондын Санхүүгийн хэлэлцээрийг соёрхон батлах тухай хуулийн төсөл /Засгийн газар 2023.12.20-ны өдөр өргөн мэдүүлсэн, соёрхон батлах/

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Батлан хамгаалахын сайд Г.Сайханбаяр, Сангийн яамны Санхүүгийн бодлогын газрын дарга Б.Сүх-Очир, мөн яамны Өрийн удирдлагын хэлтсийн ахлах мэргэжилтэн Л.Гантогтох, Онцгой байдлын ерөнхий газрын дарга Г.Ариунбуян, мөн газрын Бодлого, төлөвлөлтийн газрын дарга Л.Өлзийбаяр, Гал түймэртэй тэмцэх газрын дарга Ц.Нямбаяр, Монгол Улсын Шадар сайдын ахлах зөвлөх бөгөөд Ажлын албаны дарга Б.Мөнх-Оргил нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Хууль, эрх зүйн газрын Зөвлөхүүдийн албаны зөвлөх Д.Нямбаяр, мөн газрын Байнгын хорооны асуудал хариуцсан хэлтсийн Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хороо хариуцсан ахлах зөвлөх Ж.Чимгээ, референт Б.Гандиймаа нар байлцав.

Хуулийн төслийн талаар Батлан хамгаалахын сайд Г.Сайханбаяр танилцуулав.

Танилцуулгатай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Н.Энхболд, Г.Амартүвшин, Д.Ганбат нарын тавьсан асуултад Онцгой байдлын ерөнхий газрын дарга Г.Ариунбуян, мөн газрын Гал түймэртэй тэмцэх газрын дарга Ц.Нямбаяр, Сангийн яамны Өрийн удирдлагын хэлтсийн ахлах мэргэжилтэн Л.Гантогтох нар хариулж, тайлбар хийв.

Б.Энх-Амгалан: “Онцгой байдлын ерөнхий газарт гал унтраах тусгай зориулалтын машин нийлүүлэх төсөл”-ийг хэрэгжүүлэх Монгол Улсын Засгийн газар, Бүгд Найрамдах Франц Улсын Засгийн газар хоорондын Санхүүгийн хэлэлцээрийг соёрхон батлах тухай хуулийн төслийг дэмжье гэсэн санал хураалт явууля.

Зөвшөөрсөн: 7
Татгалзсан: 6

Бүгд: 13
53.8 хувийн саналаар дэмжигдлээ.

Байнгын хорооноос гарах санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Г.Амартүвшин Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанд танилцуулахаар тогтов.

Уг асуудлыг 11 цаг 26 минутад хэлэлцэж дуусав.

Хоёр. *“Онцгой байдлын ерөнхий газрын агаараас аврах ангид нэмэлт сургалт явуулах төсөл”-ийг хэрэгжүүлэх Монгол Улсын Засгийн газар, Бүгд Найрамдах Франц Улсын Засгийн газар хоорондын Санхүүгийн хэлэлцээрийг соёрхон батлах тухай хуулийн төсөл /Засгийн газар 2023.12.20-ны өдөр өргөн мэдүүлсэн, соёрхон батлах/*

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Батлан хамгаалахын сайд Г.Сайханбаяр, Сангийн яамны Санхүүгийн бодлогын газрын дарга Б.Сүх-Очир, мөн яамны Өрийн удирдлагын хэлтсийн ахлах мэргэжилтэн Л.Гантогтох, Онцгой байдлын ерөнхий газрын дарга Г.Ариунбуян, мөн газрын Бодлого, төлөвлөлтийн газрын дарга Л.Өлзийбаяр, Гал түймэртэй тэмцэх газрын дарга Ц.Нямбаяр, Монгол Улсын Шадар сайдын ахлах зөвлөх бөгөөд Ажлын албаны дарга Б.Мөнх-Оргил нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Хууль, эрх зүйн газрын Зөвлөхүүдийн албаны зөвлөх Д.Нямбаяр, мөн газрын Байнгын хорооны асуудал хариуцсан хэлтсийн Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хороо хариуцсан ахлах зөвлөх Ж.Чимгээ, референт Б.Гандиймаа нар байлцав.

Хуулийн төслийн талаар Батлан хамгаалахын сайд Г.Сайханбаяр танилцуулав.

Танилцуулгатай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Г.Амартүвшингийн тавьсан асуултад Онцгой байдлын ерөнхий газрын дарга Г.Ариунбуян хариулж, тайлбар хийв.

Б.Энх-Амгалан: “Онцгой байдлын ерөнхий газрын агаараас аврах ангид нэмэлт сургалт явуулах төсөл”-ийг хэрэгжүүлэх Монгол Улсын Засгийн газар, Бүгд Найрамдах Франц Улсын Засгийн газар хоорондын Санхүүгийн хэлэлцээрийг соёрхон батлах тухай хуулийн төслийг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 9
Татгалзсан: 4
Бүгд: 13
69.2 хувийн саналаар дэмжигдлээ.

Байнгын хорооноос гарах санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Г.Амартүвшин Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанд танилцуулахаар тогтов.

Уг асуудлыг 11 цаг 39 минутад хэлэлцэж дуусав.

Гурав. *Байнгын хорооны тогтоолын төсөл /Улсын Их Хурлын 2023 оны намрын ээлжит чуулганы 2024 оны 01 дүгээр сард Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хорооны хэлэлцэх асуудлын цаглавар батлах тухай/*

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Хууль, эрх зүйн газрын Байнгын хорооны асуудал хариуцсан хэлтсийн Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хороо хариуцсан ахлах зөвлөх Ж.Чимгээ, референт Б.Гандиймаа нар байлцав.

Байнгын хорооны дарга Б.Энх-Амгалан “Улсын Их Хурлын 2023 оны намрын ээлжит чуулганы 2024 оны 01 дүгээр сард Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хорооны хэлэлцэх асуудлын цаглавар батлах тухай” Байнгын хорооны тогтоолын төслийг танилцуулав.

Тогтоолын төсөлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

Б.Энх-Амгалан: “Улсын Их Хурлын 2023 оны намрын ээлжит чуулганы 2024 оны 01 дүгээр сард Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хорооны хэлэлцэх асуудлын цаглавар батлах тухай” Байнгын хорооны тогтоолын төслийг батлах санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн:	9
Татгалзсан:	4
Бүгд:	13

69.2 хувийн саналаар тогтоол батлагдлаа.

Уг асуудлыг 11 цаг 41 минутад хэлэлцэж дуусав.

Дөрөв.Элчин сайд нарыг эгүүлэн татах, томилох асуудлаар зөвшилцөх тухай
/Монгол Улсын Ерөнхийлөгчөөс 2024.01.09-ний өдөр өргөн мэдүүлсэн, зөвшилцөх/

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Гадаад харилцааны сайд Б.Батцэцэг, Монгол Улсын Ерөнхийлөгчийн Үндэсний аюулгүй байдал, улс төрийн бодлогын зөвлөх Ж.Энхбаяр, Гадаад харилцааны яамны Бодлого, төлөвлөлтийн газрын захирал Г.Бямбасүрэн, мөн яамны Төрийн захиргаа, удирдлагын газрын захирал Д.Амарсайхан, Консулын газрын захирал Б.Болд, Нэгдсэн Үндэстний Байгууллагын дэргэд суух Байнгын төлөөлөгчид нэр дэвшигч Н.Анхбаяр, Элчин сайдад нэр дэвшигч С.Сүхболд, Г.Байгалмаа, Ц.Мөнх-Өлзий нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Хууль, эрх зүйн газрын Байнгын хорооны асуудал хариуцсан хэлтсийн Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хороо хариуцсан ахлах зөвлөх Ж.Чимгээ, референт Б.Гандиймаа нар байлцав.

Монгол Улсаас гадаад улсад суух Элчин сайд нарыг томилох, эгүүлэн татах асуудлаар зөвшилцөх тухай Монгол Улсын Ерөнхийлөгчийн саналыг Монгол Улсын Ерөнхийлөгчийн Үндэсний аюулгүй байдал, улс төрийн бодлогын зөвлөх Ж.Энхбаяр танилцуулав.

Монгол Улсын Ерөнхийлөгчийн саналтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Д.Ганбатын тавьсан асуултад Гадаад харилцааны сайд Б.Батцэцэг, Элчин сайдад нэр дэвшигч С.Сүхболд, Г.Байгалмаа, Ц.Мөнх-Өлзий, Нэгдсэн Үндэстний Байгууллагын дэргэд суух Байнгын төлөөлөгчид нэр дэвшигч Н.Анхбаяр нар хариулж, тайлбар хийв.

Улсын Их Хурлын гишүүн Ц.Сэргэлэн, Д.Цогтбаатар, Б.Баттөмөр, Н.Энхболд, Б.Энх-Амгалан нар үг хэлэв.

Б.Энх-Амгалан: 1.Монгол Улсаас Бүгд Найрамдах Солонгос Улсад суух Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин сайдаар Сүхээгийн Сүхболдыг томилох саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 9
Татгалзсан: 4
Бүгд: 13
69.2 хувийн саналаар дэмжигдлээ.

2.Монгол Улсаас Бүгд Найрамдах Польш Улсад суух Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин сайдаар Гунаажавын Байгалмааг томилох саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 8
Татгалзсан: 5
Бүгд: 13
61.5 хувийн саналаар дэмжигдлээ.

3.Монгол Улсаас Шведийн Хаант Улсад суух Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин сайдаар Цэрэндоржийн Мөнх-Өлзийг томилох саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 9
Татгалзсан: 4
Бүгд: 13
69.2 хувийн саналаар дэмжигдлээ.

4.Монгол Улсаас Нэгдсэн Үндэстний Байгууллагын дэргэд суух Байнгын төлөөлөгчөөр Нямдоржийн Анхбаярыг томилох саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 9
Татгалзсан: 4
Бүгд: 13
69.2 хувийн саналаар дэмжигдлээ.

Б.Энх-Амгалан: Монгол Улсаас Бүгд Найрамдах Польш Улсад суугаа Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин сайд Бархасын Дорж, Монгол Улсаас Шведийн Хаант Улсад суугаа Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин сайд Түвдэндоржийн Жанабазар, Монгол Улсаас Нэгдсэн Үндэстний Байгууллагын дэргэд суугаа Байнгын төлөөлөгч Воршиловын Энхболд нарыг эгүүлэн татах саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 10
Татгалзсан: 3
Бүгд: 13
76.9 хувийн саналаар дэмжигдлээ.

Байнгын хорооноос гарах санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Б.Энх-Амгалан Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанд танилцуулахаар тогтов.

Уг асуудлыг 12 цаг 33 минутад хэлэлцэж дуусав.

Тав. “Бүгд Найрамдах Узбекистан Улсын нийслэл Ташкент хотод Монгол Улсын элчин сайдын яам нээн ажиллуулах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл /Засгийн газар 2024.01.08-ны өдөр өргөн мэдүүлсэн, зөвшилцөх/

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Гадаад харилцааны сайд Б.Батцэцэг, Гадаад харилцааны яамны Төрийн нарийн бичгийн дарга Н.Анхбаяр, мөн яамны Төрийн захиргаа, удирдлагын газрын захирал Д.Амарсайхан, Ази, номхон далайн орнуудын газрын захирал Г.Хулан, Санхүү, эдийн засгийн хэлтсийн дарга Ч.Ганбат нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Хууль, эрх зүйн газрын Байнгын хорооны асуудал хариуцсан хэлтсийн Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хороо хариуцсан ахлах зөвлөх Ж.Чимгээ, референт Б.Гандиймаа нар байлцав.

Тогтоолын төслийн талаар Гадаад харилцааны сайд Б.Батцэцэг танилцуулав.

Тогтоолын төсөлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Д.Ганбатын тавьсан асуултад Гадаад харилцааны сайд Б.Батцэцэг хариулж, тайлбар хийв.

Улсын Их Хурлын гишүүн Б.Баттөмөр, Н.Энхболд, Г.Амартүвшин, Б.Энх-Амгалан нар үг хэлэв.

Н.Энхболд: “Бүгд Найрамдах Узбекистан Улсын нийслэл Ташкент хотод Монгол Улсын элчин сайдын яам нээн ажиллуулах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 8
Татгалзсан: 4
Бүгд: 12
66.7 хувийн саналаар дэмжигдлээ.

Байнгын хорооноос гарах санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Х.Баделхан Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанд танилцуулахаар тогтов.

Уг асуудлыг 12 цаг 56 минутад хэлэлцэж дуусав.

Байнгын хорооны нээлттэй хуралдаанаар 5 асуудал хэлэлцэв.

Нээлттэй хуралдаан 2 цаг 00 минут үргэлжилж, 17 гишүүнээс 13 гишүүн хүрэлцэн ирж, 76.5 хувийн ирцтэйгээр 12 цаг 56 минутад өндөрлөв.

Тэмдэглэлтэй танилцсан:
АЮУЛГҮЙ БАЙДАЛ,
ГАДААД БОДЛОГЫН
БАЙНГЫН ХОРООНЫ ДАРГА

Б.ЭНХ-АМГАЛАН

Тэмдэглэл хөтөлсөн:
ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛ
ХӨТЛӨХ АЛБАНЫ ШИНЖЭЭЧ

Д.УЯНГА

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРАЛ

2024 оны 01 дүгээр сарын 10-ны өдөр,
Лхагва гараг
Төрийн ордон “Их эзэн Чингис хаан”
танхим
9 цаг 59 минут.

АЮУЛГҮЙ БАЙДАЛ, ГАДААД БОДЛОГЫН БАЙНГЫН ХОРООНЫ ХУРАЛДААНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ

Б.Энх-Амгалан: Ажлын хэсгээ оруулъя. Эрхэм гишүүдийн энэ өдрийн амгаланг айлтгая. Байнгын хорооны гишүүдийн ирц бүрдсэн тул Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хорооны 2024 оны 1 дүгээр сарын 10-ны өдрийн хуралдааныг нээснийг мэдэгдье. Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 11.6-д заасны дагуу хуралдааны ирцийг танилцуулъя. Бямбасүрэнгийн Энх-Амгалан ирсэн, Норовын Алтанхуяг чөлөөтэй, Ганибалын Амартүвшин ирсэн, Пүрэв-Очирын Анужин ирсэн, Хавдисламын Баделхан ирсэн, Энхтайвангийн Бат-Амгалан чөлөөтэй, Баагаагийн Баттөмөр ирж байгаа, Бадмаанямбуугийн Бат-Эрдэнэ ирсэн, Сүхбаатарын Батболд чөлөөтэй, Дашдондогийн Ганбат ирсэн, Борхүүгийн Дэлгэрсайхан Дэлгэрсайхан гишүүнийг ирцдээ орчих гээрэй. Нанзадын Наранбаатар гишүүн ирээгүй байна, ир гээрэй. Салдангийн Одонтуяа гишүүн ирсэн байна. Цэдэвийн Сэргэлэн гишүүн ирээгүй байна, юу яагаарай асуугаадхаарай. Дамдины Цогтбаатар гишүүн ирсэн байна, Нямаагийн Энхболд гишүүн ирсэн байна. Жаргалтулгын Эрдэнэбат гишүүн чөлөөтэй байна. Ингээд гишүүдийн ирцийг танилцуулж дууслаа.

Хэлэлцэх асуудлаа танилцуулъя. 1.Зэвсэгт хүчний зэвсэг, техникийг шинэчлэх сэргээн сайжруулах бодлогыг батлах тухай Монгол Улсын Их Хурлын тогтоолын төсөл, Засгийн газар 2023

оны 10 сарын 23-ны өдөр өргөн мэдүүлсэн, анхны хэлэлцүүлэг, хаалттай. 2.Онцгой байдлын ерөнхий газарт гал унтраах тусгай зориулалтын машин нийлүүлэх төслийг хэрэгжүүлэх Монгол Улсын Засгийн газар Бүгд Найрамдах Франц Улсын Засгийн газар хоорондын санхүүгийн хэлэлцээрийг соёрхон батлах тухай хуулийн төсөл, Засгийн газар 2023 оны 10 сарын 20-ны өдөр өргөн мэдүүлсэн. 3.Онцгой байдлын ерөнхий газрын Агаараас аврах ангид нэг нэмэлт сургалт явуулах төслийг хэрэгжүүлэх Монгол Улсын Засгийн газар Бүгд Найрамдах Франц Улсын Засгийн газар хоорондын санхүүгийн хэлэлцээрийг соёрхон батлах тухай хуулийн төсөл, Засгийн газар 2023 оны 12 сарын 20-ны өдөр өргөн мэдүүлсэн. 4.Монгол Улсын Их Хурлын 2023 оны намрын ээлжит чуулганы 2024 оны 1 дүгээр сард Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хорооны хэлэлцэх асуудлын цаглавар батлах тухай Байнгын хорооны тогтоолын төсөл. 5.Бусад асуудлын хүрээнд 2 асуудал хэлэлцэнэ. 1.Элчин сайд нарыг эргүүлэн татах, томилох асуудлаар зөвшилцөх тухай, Монгол Улсын Ерөнхийлөгч 2024 оны 1 сарын 5-ны өдөр ирүүлсэн, зөвшилцөх. 2-т Бүгд Найрамдах Узбекистан Улсын нийслэл Ташкент хотод Монгол Улсын Элчин сайдын яам нээн ажиллуулах тухай Улсын Их Хурлын тогтоолын төсөл, Засгийн газар 2024 оны 1 сарын 9-ний өдөр өргөн мэдүүлсэн. Ийм 5 асуудлын хүрээнд хэлэлцэх асуудлыг танилцуулж байна.

Хэлэлцэх асуудлын талаар саналтай гишүүн байна уу? Алга байна. Хэлэлцэх асуудалдаа оръё. Эхний асуудал Зэвсэгт хүчний зэвсэг, техникийг шинэчлэх, сэргээн сайжруулах бодлогыг батлах тухай Монгол Улсын Их Хурлын тогтоолын төслийн анхны хэлэлцүүлгийг хийе. Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 22.3-д хэлэлцэх асуудлын шинж байдал, гишүүдийн саналыг харгалзан асуудлыг хаалттай хуралдаанаар хэлэлцэж болно гэж. Төрийн болон албаны нууцын тухай хуулийн 13 дугаар

зүйлд батлан хамгаалах хүрээнд Зэвсэгт хүчний байлдааны бэлэн байдлыг тодорхойлсон нэгдсэн үзүүлэлт, мэдээлэл, Зэвсэгт хүчнийг бэхжүүлэх, хэрэглэх болон стратегийн төлөвлөлтийн бичиг баримтыг төрийн нууцад хамааруулах мэдээлэлд хамаарна гэж заасны дагуу Байнгын хороо энэ тогтоолын төслийг хэлэлцэх эсэх асуудлыг хаалттай хуралдаанаараа хэлэлцсэн болно. Мөн тогтоолын төслийн анхны хэлэлцүүлгийг хаалттай хуралдаанаар хэлэлцүүлэхээр энэ долоо хоногийн хуралдаанаар хэлэлцэх асуудлын тов дараалалд орсон байгаа тул Байнгын хорооны хуралдааныг хаалттай горимд шилжүүлье. Хуралдааныг хаалттай горимд шилжүүлье.

10.03 цаг

Хуралдаан 11 цаг 00 минутаас нээлттэй горимд шилжив.

Ажлын хэсгийн гишүүддээ баярлалаа. Хуралдааны дараагийн асуудалд оръё. Ажлын хэсгийнхнийгээ оруулчхаарай. Одоо хэлэлцэх 5 асуудал бүгдээрээ санал хураалттай. Тийм учраас гишүүдээ байж байгаарай. Өмнө нь хэлэлцчихсэн асуудлууд учраас бас гайгүй асуудлууд байгаа. Ажлын хэсгээ оруулчихъя. Нөгөө онцгой байдлын асуудал байгаа юм. Ажлын хэсэг оруулчих, нээлттэй горимд шилжсэн үү? Ажлын хэсэг оруулчих, дуудаарай.

Нэг. “Онцгой байдлын ерөнхий газарт гал унтраах тусгай зориулалтын машин нийлүүлэх төсөл”-ийг хэрэгжүүлэх Монгол Улсын Засгийн газар, Бүгд Найрамдах Франц Улсын Засгийн газар хоорондын Санхүүгийн хэлэлцээрийг соёрхон батлах тухай хуулийн төсөл /Засгийн газар 2023.12.20-ны өдөр өргөн мэдүүлсэн, соёрхон батлах/

Дараагийн асуудалдаа оръё. 2.ОБЕГ-т гал унтраах тусгай зориулалтын машин нийлүүлэх төслийг

хэрэгжүүлэх, Монгол Улсын ЗГ Бүгд Найрамдах Франц Улсын ЗГ хоорондын санхүүгийн хэлэлцээрийг соёрхон батлах тухай хуулийн төслийг хэлэлцье. Хэлэлцэж байгаа асуудалтай холбогдуулан хуралдаанд оролцож байгаа албан тушаалтнуудыг танилцуулъя. Болдын Жавхлан Монгол Улсын Их Хурлын гишүүн, ЗГ-ын гишүүн Сангийн сайд, Жавхлан сайд хаана байна вэ? Сангийн яамнаас хэн байгаа юм бэ, оруулаарай. Гомбожавын Ариунбуян ОБЕГ-ын дарга, хошууч генерал, 3 номерын микрофон дээр сууж байна. Батсүхийн Сүх-Очир Сангийн яамны Санхүүгийн бодлогын газрын дарга. Сангийн яамныхан хааччихсан юм бэ, дуудаадах даа. Лувсанишаравын Өлзийбаяр ОБЕГ-ын Бодлого, төлөвлөлтийн газрын дарга, хурандаа. Цэдэвийн Нямбаяр ОБЕГ-ын Гал түймэртэй тэмцэх газрын дарга, хурандаа, Булганхүүгийн Ганзориг Сангийн яамны хөгжлийн санхүүжилтийн хэлтсийн дарга. Ажлын хэсгийнхэн алив энэ Сангийн яамныхныг дууд. Хэрвээ Сангийн яамныхан байхгүй бол энэ асуудал хойшлогдлоо шүү. Яагаад цагтаа байдаггүй юм бэ энэ чинь. Батсүхийн Сүх-Очир, Булганхүүгийн Ганзориг Сангийн яамны энэ 2 даргыг дууд.

ОБЕГ-т гал унтраах тусгай зориулалтын машин нийлүүлэх төслийг хэрэгжүүлэх Монгол Улсын ЗГ Бүгд Найрамдах Франц Улсын ЗГ хоорондын санхүүгийн хэлэлцээрийн төслийн зөвшилцөх асуудлыг Эдийн засгийн байнгын хороо 2023 оны 10 дугаар сарын 5-ны өдрийн хуралдаанаараа хэлэлцэж, дэмжсэн санал, дүгнэлт гаргасан. Мөн Аюулгүй байдал, гадаад бодлогын болон Төсвийн байнгын хорооны 2023 оны 10 дугаар сарын 5-ны өдрийн хамтарсан хуралдаанаар уг асуудлыг хэлэлцэж, дэмжсэн талаарх санал, дүгнэлтээ ЗГ-т хүргүүлсэн болно. Хуулийн төслийн талаарх танилцуулгыг Монгол Улсын ЗГ-ын гишүүн, Батлан хамгаалахын сайд Гүрсэдийн Сайханбаяр танилцуулна. Сайханбаяр сайдын микрофоныг өгье, 2

номерын микрофон. Сангийн яамныхан орж ирж байна уу тийм ээ, наашаа урагшаа суу.

Г.Сайханбаяр: Байнгын хорооны дарга, эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын ЗГ Бүгд Найрамдах Франц улсын ЗГ хооронд 2019 онд байгуулсан санхүүгийн хэлэлцээрийн хүрээнд онцгой байдлын байгууллагад агаараас эрэн хайх, аврах анги байгуулах, нисдэг тэрэг нийлүүлэх, гал унтраах тусгай зориулалтын автомашин нийлүүлэх төслийг амжилттай хэрэгжүүлсэн. Төслийн хүрээнд 4 нисдэг тэрэг нийлүүлэгдэж, евро стандартын симулятор, засвар үйлчилгээний төв оффис бүхий ангартай агаараас эрэн хайх аврах анги байгуулагдаж, нисгэгч, инженер техникийн ажилтнуудыг бэлтгэж байна. Тус анги 2023 оны 12 дугаар сарын байдлаар нийт 94 удаагийн тусгай үүргийн нислэг үйлдэж, ослын улмаас бэртэж гэмтсэн газраар тээвэрлэх боломжгүй нөхцөлд байсан 133 хүний амь насыг аварч.../үг тасрав/

Б.Энх-Амгалан: Сайханбаяр сайдаа эхний асуудал энэ гал унтраах зориулалтын автомашины тухай төсөл байна. Та 2 дахь асуудлыг танилцуулаад байх шиг байна. Эхнээс нь дахиад танилцуулъя.

Г.Сайханбаяр: Уучлаарай. Байнгын хорооны дарга, эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын ЗГ Бүгд Найрамдах Франц улсын ЗГ хооронд 2019 онд байгуулсан Санхүүгийн хэлэлцээрийн хүрээнд онцгой байдлын байгууллагад агаараас эрэн хайх, аврах анги байгуулах, нисдэг тэрэг нийлүүлэх, гал унтраах тусгай зориулалтын автомашин нийлүүлэх төслийг амжилттай хэрэгжүүлсэн. Төслийн хүрээнд 42 гал унтраах тусгай зориулалтын автомашин нийлүүлэгдсэн бөгөөд 2023 оны 12 дугаар сарын байдлаар 2343 удаагийн дуудлагаар үүрэг гүйцэтгэж, 1699 хүний амь нас, аюулгүй байдлыг

хамгаалан ажиллаж, 357,8 тэрбум төгрөгийн үнэ бүхий эд хөрөнгийг хамгаалсан байна. Монгол Улсын ЗГ-аас энэ төслийн хэрэгцээ, шаардлага, ач холбогдлыг харгалзан дараагийн шатын төслийг хэрэгжүүлэхээр шийдвэрлэж, гэрээ байгуулах санал, гэрээний төслийг урьдчилан Улсын Их Хурлын Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хороо болон Төсвийн байнгын хороо, Эдийн засгийн байнгын хорооны хуралдаанаар хэлэлцүүлж зөвшилцсөн.

Монгол Улсын Ерөнхийлөгч Ухнаагийн Хүрэлсүхийн Бүгд Найрамдах Франц Улсад хийсэн төрийн айлчлалын үеэр ОБЕГ-т гал унтраах тусгай зориулалтын машин нийлүүлэх төслийг хэрэгжүүлэх санхүүгийн хэлэлцээрт Монгол Улсын Сангийн сайд Жавхлан Бүгд найрамдах Франц Улсын Жижиг, дунд үйлдвэр, худалдаа аялал жуулчлалын асуудал эрхэлсэн сайд Оливия Грегуар нар 2023 оны 10 дугаар сарын 13-ны өдөр Парис хотноо гарын үсэг зурсан болно. Энэ хэлэлцээрийн дагуу жилийн 0,282 хувийн хүүтэй, 20 жилийн хугацаатай, 13,3 сая евротой тэнцэх хэмжээний нэн хөнгөлөлттэй зээл авах юм. Төслийн 2 дугаар шатыг хэрэгжүүлснээр хэт хүйтний болон давчуу орчин нөхцөлд ажиллах чадвартай хөөсөөр гал түймэр унтраах болон 32, 42 метр хүртэлх өндөрт ажиллах шатын 18 нэгж гал түймэр унтраах тусгай зориулалтын автомашин нийлүүлэгдэх болно. Эдгээр автомашинууд нийлүүлэгдсэнээр онцгой байдлын байгууллагад ашиглагдаж байгаа гал түймэр унтраах автомашин техник тоног төхөөрөмжийн хүчин чадал нэмэгдэж ялангуяа газрын тосны бүтээгдэхүүн хадгалах агуулах, ШТС болон томоохон хэмжээний худалдааны төв байгууламжид гарсан гал түймрийг унтраах түргэн шуурхай унтраах чадавч эрс сайжрах болно.

ОБЕГ-т гал унтраах тусгай зориулалтын машин нийлүүлэх төслийг хэрэгжүүлэх санхүүгийн хэлэлцээрийг соёрхон батлах хуулийн төслийг ЗГ-ын

хуралдаанаар хэлэлцэн шийдвэрлэсний дагуу Улсын Их Хуралд 2023 оны 12 дугаар сарын 20-ны өдөр өргөн мэдүүлсэн болно. Хуулийн төсөл батлагдсантай холбогдуулан цаашид шинээр боловсруулах буюу нэмэлт, өөрчлөлт оруулах, хүчингүй болгох хууль тогтоомж байхгүй болно.

Байнгын хорооны дарга, эрхэм гишүүд ээ,

ОБЕГ-т гал унтраах тусгай зориулалтын машин нийлүүлэх төслийг хэрэгжүүлэх санхүүгийн хэлэлцээрийг соёрхон батлах хуулийн төслийг хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг хүсье. Анхаарал тавьсанд баярлалаа.

Б.Энх-Амгалан: Сайханбаяр сайд баярлалаа. Хуулийн төсөлтэй холбогдуулан үг, асуулт асуух гишүүд байвал нэрээ өгнө үү? Ганбат гишүүнээр тасаллаа. Нямаагийн Энхболд гишүүн асуултаа асууя.

Н.Энхболд: Би ерөнхийд нь дэмжиж байгаа энэ хэлэлцээрийг. 2 асуулт байна. 1 дүгээрт өнөөдөр манайд энэ хөөсөөр гал унтраадаг тийм машин тоног төхөөрөмж хүчин чадал байна уу? Дандаа усаар уу? 2 дугаарт энэ 32, 42 метр гэдэг чинь хүмүүст ойлгомжтой. Асуухад хэдэн давхар байшинд дээд тал нь хүрч энэ гал унтраах ажлаа явуулах вэ? Одоо чинь манайд 25, 26 цаашидаа бараг 30, 40 метр өндөр юу давхар байшин барина гэсэн юмнууд байгаа юм байна лээ шүү дээ. Тэгээд 3 дахь асуулт энэ өндөр байшингуудад ялангуяа энэ орон сууцын өндөр байшингуудад гал гарвал тэрэнтэй тэмцэх, тэрнийг унтраах, унтраах албан ёсоор баталсан тийм стандартууд байна уу? Барилга барьж байгаа компаниудад яг тийм шаардлагыг нь тавьж байна уу? Зөрчилтэй газар хэр олон байгаа вэ? Сүүлийн үед чинь дандаа л 20 хэдэн давхар байшин барьдаг болчихлоо шүү дээ. Тэгэхээр энд нь стандарт нь байна уу? Танайх хяналт тавьдаггүй уу, хэд нь тийм шаардлага хангаагүй өндөр

байшин барьчихсан, гал унтраах ямар ч боломжгүй гарцгүй ч байдаг юм уу эсхүл байшин өөрөө байшингууд чинь өөрснөө давхар болгондоо нэг ийм шахдаг гал унтраах юмнуудтай байх ёстой шүү дээ. Дохиололтой байх ёстой, давхар болгондоо усаар ядаж галаа унтраадаг ийм юмнуудтай байх ёстой. Тийм юм бүх байшингуудад байгаа юу? Хэр хяналт тавьж байгаа вэ?

Б.Энх-Амгалан: Хэн хариулах вэ? 3 номерын микрофон ОБЕГ-ын дарга хариулъя.

Г.Ариунбуян: Байнгын хорооны дарга, гишүүдийнхээ өдрийн амгаланг айлтгая. Энхболд гишүүний асуултад хариулъя. Өнөөдөр онцгой байдлын байгууллагад хөөсөөр гал унтраах зориулалттай 3 автомашин байгаа. Ер нь болбол бидний хэрэгцээ бол 17 ангид ийм хөөсөөр унтраах тусгай зориулалтын шатны машин байх шаардлага хэрэгцээ бол бий. Улсын хэмжээнд ер нь бол сүүлийн жилүүдэд өндөр барилга байгууламжууд их баригдаж байна. Улаанбаатар хотод гэхэд Статистикийн хорооны гаргасан судалгаагаар 198 ширхэг олон нийтийн зориулалттай худалдаа, үйлдвэрлэл үйлчилгээний, орон сууцын зориулалттай 9 давхраас дээш ийм барилга байгууламж байгаа. Онцгой байдлын байгууллагад ашиглагдаж байгаа автомашинууд өнөөдөр бол 5 буюу дээд тал нь 8 давхар хүртэл үүрэг гүйцэтгэх ийм боломжтой. 42 метрийн шат, 32 метрийн шат нь бол 12 ба түүнээс дээш давхарт хүрч гамигийн голомтод үүрэг гүйцэтгэх боломж бас бүрдэх юм гэдгийг хэлье.

Энэ стандарт байдаггүй гэдэг дээр бол ер нь бол гал унтраах аврах хэсэг тусгай нэгжид тавигдах 2013 оны Монгол Улсын MNS гэдэг стандарт шаардлага байдаг. Энэ стандартад тавигдсанаар тухайн барилга байгууламжийг унтраахад шатны автомашин хөөсөөр унтраах автомашинтай байх ёстой гэдэг ийм

шаардлага бол тавигддаг. 2 дугаарт нь энэ барилга байгууламжийн аюулгүй байдлыг хангах хүрээнд сүүлийн жилүүдэд баригдаж байгаа барилгуудад дотоод дотуур дохиолол хамгаалал, гал унтраах тусгай зориулалтын багаж хэрэгслүүд, гал унтраагуурыг заавал суурилуулах, үүнийг бол барилгын хүлээж авах ажлын хэсэг байнга шаардаж ажиллаж байна.

Б.Энх-Амгалан: Хариулт хангалттай юу? Нямаагийн Энхболд гишүүн тодруулж асууя.

Н.Энхболд: Тэр олон барилгуудаас чинь одоо яг стандартад нийцсэн галын аюулаас урьдчилан сэргийлэх, гал түймэртэй тэмцэх тэр дохиоллын систем, унтраах хэрэгсэлгүй нь хэд байна вэ? Тооцоо судалгаа байна уу? 200-гаад юмнаас.

Б.Энх-Амгалан: Хариулъя, хэдэн номерын микрофон, 1 номерын микрофон, хэн гэдэг хүн, албан тушаал, нэрээ хэлээд хариулаарай.

Ц.Нямбаяр: Нямаагийн Энхболд гишүүний асуултад хариулъя. ОБЕГ-ын Гал түймэртэй тэмцэх газрын дарга, хурандаа Нямбаяр. Улаанбаатар хотод буюу улсын хэмжээнд байгаа энэ өндөр барилгуудын норм стандартыг болбол БХБЯ-наас баталсан Барилгын норм ба дүрэм 21-н 02 гэдэг энэ барилгын дүрмээр энэ таны саяын асуусан зүйлүүдийг болбол байхыг нормчилж өгсөн байдаг. Өндөр барилга Улаанбаатар хотод байгаа энэ 20-оос дээш давхар барилгуудад болбол гал унтраах автомат тоноглолын систем буюу өөрөө өөрийгөө унтраах ийм системээр тоноглон байхыг болбол барилгын зураг төсөл зохиох шатаас нь авхуулаад Онцгой байдлын байгууллага дээр галын аюулгүй байдлын экспертизийн дүгнэлтийг манай байгууллага хариуцаж гаргаж ажилладаг. Яг өнөөдрийн байдлаар энэ норм дүрмийг зөрчсөн буюу норм дүрмийн стандартыг шаардлагыг

хангаагүй ийм барилгыг болбол.../минут дуусав/

Б.Энх-Амгалан: Гүйцээгээд хариулчихъя. 1 номерын микрофоныг нэмж өгье.

Ц.Нямбаяр: Улсын комисст ажиллах энэ улсын комиссын барилга байгууламжийг байнгын ашиглалтад авах энэ улсын комисс дээрээ болбол энэ шаардлагыг хангаагүй барилга байшинг бол хүлээж авах эрх зүйн үндэс байхгүй. Тэгэхээр болбол одоогоор болбол яг энэ гал унтраах систем төлөвлөгдөөгүй буюу хийгдээгүй ийм барилга байшин байхгүй. Гарсан барилга байгууламжийг байнгын ашиглалтад авах энэ комиссын дүгнэлт дээр дутагдалтай барилгыг болбол хүлээж авахгүй гэдэг саналаа онцгой байдлын байгууллагыг төлөөлж оролцож байгаа төлөөлөл бол илэрхийлээд, энийг хийж хэрэгжүүлэх ажлыг бол хуулийн хүрээнд ингээд шаардлага тавиад ажиллаж байгаа.

Б.Энх-Амгалан: Ганибалын Амартүвшин гишүүн асуулт асууя.

Г.Амартүвшин: Би Энхболд гишүүний асуулт бас ижил төстэй асуулт л байна л даа. Хан-Уул дүүрэгт баригдаж байгаа барилгуудын дийлэнх олонх нь ерөөсөө 16 давхраас дээш, 12 давхраас дээш тийм өндөртэй барилгууд баригдаад байна л даа. Тэгэхээр 16 давхар чинь нэг ойролцоо 50 метр өндөр гэж тооцоолдог юм байна шүү дээ, дунджаар тийм ээ? Тэгэхээр ямар ч гэсэн манайд бол 50 метрт хүрэх тийм гал унтраах техник хэрэгсэл байхгүй л гэж би ойлгоод байна тийм ээ? Тэгэхээр энэ Францын энэ шинэ гэрээгээр бол авто механик шатын автомашин 32 метрт хүрэх 10 ширхэг, 42 метрт хүрэх 5 ширхэг юм байна гэж ойлголоо тийм ээ. Тэгэхээр энэ тодорхой хэмжээгээр мэдээж хэрэг бол гал унтраах бүрэлдэхүүнд бол том эерэг нэмэлт хүчин чадал нэмж байгаа л гэж харагдаж байна л даа.

Гэхдээ л хангалтгүй л юм байна л даа яаж ч бодсон. 23 давхарт юм уу, 22 давхарт гал унтраах гал гарвал тэрийг унтраахад бол нэлээн төвөгтэй л асуудал болох нь дээ. Энэ дээр манай онцгой байдлынхан ямар юуны стратеги, тактик баримталдаг юм бол ингэж асуумаар байгаа юм. 2 дугаарт өмнө нь яах вэ энэ нь бол нөгөө нисдэг тэрэгтэй холбоотой болохоор би дараагийн асуудал дээр. Тэгэхдээ энэ худалдаж авч байгаа техник нь бүгд шинэ юм байгаа биз дээ? Цоо шинэ техник л гэж ойлгоё.

Б.Энх-Амгалан: Хариулъя. Гомбожавын Ариунбуян ОБЕГ-ын дарга, хошууч генерал хариулъя, 3 номерын микрофоныг өгье.

Г.Ариунбуян: Амартүвшин гишүүний асуултад хариулъя. Энэ нийлүүлэх төслийн хүрээнд нийлүүлэгддэг автомашинууд бол бүгд цоо шинэ үйлдвэрээс гарсан евро стандартын шаардлагыг хангасан, дээр нь манай улс орны улирлын нөхцөл байдалд тохирсон. Бид нар бол бас энэ техникийн тодорхойлолт дээрээ энэ талаар нэлээн тусгаж өгч ажиллана. 2 дугаарт нь энэ 12 давхраас дээш энэ барилга байгууламжид гал түймэр гарсан тохиолдолд эдгээр цөөн тооны ч гэсэн автомашин бол үүрэг гүйцэтгэж ямар ч байсан иргэдийн амь нас, эд хөрөнгөд учрах хохирлыг бууруулахад бас томоохон дэмжлэг болох юм. Мэдээж өндөр барилгад гарч байгаа гал дээр бид нар бол тактик ажиллагаагаа гал унтраах ажиллагааныхаа хүрээнд бол байнга тогтмол авч хэрэгжүүлж ажиллана. 16 давхар түүнээс дээш барилгад гарсан галыг унтраах тал дээр 1 дүгээрт энэ Барилгын хөгжлийн яамнаас тавигдаж байгаа энэ стандарт норм дүрмийг хэрэгжүүлэх, барилгын байнгын ашиглалтад хүлээж авах ажилд манайхаас томилогдож ажиллаж байгаа тэр субъект бас энэ норм, дохиолол системийг бол бүрэн ашиглалтад оруулах тал дээр анхаарч ажиллана. Тэгээд гал гарсан тохиолдолд бид нар шуурхай унтраах ажиллагаагаа

давхар зохион байгуулаад ингээд ажиллах юм. Цаашидаа ч гэсэн энэ гал унтраах техник тоног төхөөрөмжийн хүчин чадлыг сайжруулах, тоо хэмжээг нэмэгдүүлэх хэрэгцээ шаардлага бол онцгой байдлын байгууллагад бол байна.

Б.Энх-Амгалан: Баярлалаа. Дашдондогийн Ганбат гишүүн асуултаа асууя.

Д.Ганбат: Энэ юу юм байна. Энэ бол бас л 13 сая еврогоор бол энэ ЗГ-ын өр нэмэгдэх юм байна л даа. Энэ чинь юу билээ? Өнөөдрийг хүртэл 8,1 тэрбум долларын өртэй болчихсон байгаа л даа Монгол Улсын ЗГ. Тэгээд энэ дээр л нэмэгдэх нь. Өмнө нь бол 2016 он хүртэл бол ЗГ-ын өр 4,5 тэрбум байсан. Энэ чинь бараг зуугаад жилд хуримтлагдсан өр шүү дээ. Тэгээд сүүлийн 7, 8 жилд ингээд 3,6-гаар нэмэгдэх нь. Энэ дээр 13 сая евро нэмэгдэх нь. Тэгээд яах вэ өөрсдөө бол ЗГ-ын мөнгө төгрөг гэж юу байх вэ дээ, ЗГ-т ямар юмны мөнгө байх вэ. Нөгөө татвар төлөгчдийн л мөнгийг ингэж зарцуулж байгаа юм л даа гэсэн ийм юм байгаа. Энэ мөнгийг үр дүнтэй сайн зарцуулах хэрэгтэй. Онцгой байдлын газар энэ техник технологийг шинэчлэх энэ бол зөв зүйтэй гэж үзэж байна. Гэхдээ энэ машинууд чинь тэгээд энд тэндээс ингээд аваад байж бас болохгүй шүү дээ. Манай урд хөршид үйлдвэрлэгч орон, дэлхий нийтийн хамаг том, том үйлдвэрүүд бүгд тэнд байна. Тэгээд ямар маркийн машин, ямар машинууд орж ирэх юм бэ?

Нөгөө засвар үйлчилгээ гээд ингээд цаашидаа явна. Хувийн хэвшил бол энэ юманд бол шал өөр ханддаг л даа. Дистрибьютер нь үйлчилгээ үзүүлэх энэ бүх зүйлүүд нь байгаа юу энэ улс оронд. Нэг хэсэг хэдхэн машин аваад л 5, 6 жил ашиглаад л, дараа нь нөгөө сэлбэг хэрэгсэл, техник тоног төхөөрөмж аягүй үнэтэй. Энийгээ тэгээд ашиглаж чадахгүй ийм байдал ордог. Уг нь тэр парк бол нэг загварын ийм тоног төхөөрөмжөөр бүрдүүлчихсэн, тэр үйлчилгээ үзүүлдэг нэгж нь Монгол

Улсад байвал зөв л дөө. Тэгэхгүй бол бас энэ автобусыг хар, энэ ногоон автобус, баахан тэгээд нөгөө юу билээ яг тэр үйлдвэрийн автобус нь биш ийм юмыг явж, явж байгаад л хамгийн сүүлд нь энэ Хятадаас л хэдэн автобус оруулж ирж, ингэж ажиллаж байх шиг байна. Тэгээд ийм юмыг судалгаа тооцоо гарсан уу? Яагаад гэвэл гэхээр энэ чинь хамгийн цаад тал нь татвар төлөгчдийн л мөнгийг зарцуулж байгаа болохоор, өр болохоор би тэгж яриад байгаа юм л даа.

Б.Энх-Амгалан: Ганбат гишүүний эхний тэр өрийн тааз чинь юу болж байгаа юм бэ? Монгол Улсын гадаад өр 13,3 сая еврогоор нэмэгдэж байна, ингээд өр тавиад байх нь зөв юм уу энэ тэр гэсэн байдлаар асууж байгаа тэр асуултад Сангийн яам хариулъя. Сангийн яамнаас хэн байна вэ, 4 номерын микрофон Булганхүүгийн Ганзориг мөн үү? Өөрийгөө танилцуулаад хариулаарай. Тэгээд дараа нь нэмээд Ариунбуян генерал хариулъя.

Л.Гантогтох: Ганбат гишүүний асуултад хариулъя. Сангийн яамны Өрийн удирдлагын хэлтсийн ахлах мэргэжилтэн Гантогтох. ЗГ-ын өрийн хязгаар бол Төсвийн тогтвортой байдлын тухай хуулийн 6.1.4-д заасны дагуу ЗГ-ын өнөөгийн үнэ цэнээр илэрхийлсэн үлдэгдлийн ДНБ-д харьцуулсан харьцаа 60 хувь буюу түүнээс доош байхаар заасан байгаа. 2023 оны 3 дугаар улирлын байдлаар энэ гүйцэтгэл бол ЗГ-ын өрийн өнөөгийн үнэ цэнээр илэрхийлсэн үлдэгдлийн ДНБ-д харьцуулсан харьцаа 44,3 хувьтай тэнцэж байгаа. Энэ онцгой байдлын төслийн шинэ гэрээ авснаар 2024 онд энэхүү төсөл ашиглалтад орсноор ЗГ-ын өрийн энэ хязгаар бол гүйцэтгэл нь 42,7 хувьд хүрэхээр байгаа. Ирэх жил 24 оны төсвийн төсөлд шинээр авах гадаад зээлийн ашиглалтын хэмжээ бас 1,2 их наяд гэж хязгаар заасан байгаа. Энэ дотор бас энэ онцгой байдлын төслийн гэрээний ашиглалт бас тооцогдсон байгаа. Тэгэхээр яг ЗГ-ын өрийн хязгаарт бол энэ төсөл багтаж байгаа.

Б.Энх-Амгалан: Нэмээд 3 номерын микрофон Ариунбуян генерал хариулъя.

Г.Ариунбуян: Ганбат гишүүний асуултад хариулъя. Ер нь бол онцгой байдлын байгууллагаас энэ техник тоног төхөөрөмжийн чадавхыг сайжруулах хүрээнд ер нь евро стандартын шаардлага хангасан автомашинтай байх ийм асуудал дээр их бодлогын анхаарал тавьж ажиллаж байна. Тийм учраас энэ Францад үйлдвэрлэсэн автомашинууд бол манай Монгол Улсын ер нь өвөрмөц цаг агаарын нөхцөл байдалд тохирсон, манай техникийн шаардлагыг бол хангасан, евро стандартад нийцсэн ийм машинууд нийлүүлэгдэнэ. Урьд нь нийлүүлэгдсэн 42 автомашин бол яг л ийм л зориулалттай Францын машин. Тэгэхдээ бол Францын Рейно компанид үйлдвэрлэсэн машинууд нийлүүлэгдэнэ. Засвар үйлчилгээний хувьд бол Монгол Улсад үйл ажиллагаа явуулж байгаа энэ Рейно компанийн дистрибьютер компаниар энэ засвар үйлчилгээг хийлгэнэ. Урьд нь нийлүүлсэн 42 автомашин бас яг ийм хэлбэрээр бид нар ажиллаж байгаа.

Хангамжийн хувьд бол цаашидаа бол мэдээж өөрийнхөө батлагдсан төсвийн хүрээнд шаардлагатай техник тоног төхөөрөмж, сэлбэг хэрэгслүүдийн хангамжийг бол тасралтгүй зохион байгуулаад явна. Албан хаагчдаа энэ төсөл хэрэгжүүлэх хугацаанд бас сургалт зохион байгуулж, ашиглах, засвар үйлчилгээ хийх тал дээр бас дотоод боловсон хүчнээ давхар бэлтгэх ийм асуудлууд явна.

Б.Энх-Амгалан: Баярлалаа. Гишүүд асуулт асууж, хариулт авч дууслаа. Хуулийн төсөлтэй холбогдуулан үг хэлэх гишүүд байвал нэрээ өгнө үү? Алга байна. Санал хураалт явуулна. Онцгой байдлын ерөнхий газарт гал унтраах тусгай зориулалтын машин нийлүүлэх төслийг хэрэгжүүлэх Монгол Улсын ЗГ Бүгд Найрамдах Франц Улсын

ЗГ хоорондын санхүүгийн хэлэлцээрийг соёрхон батлах тухай хуулийн төслийг дэмжье гэсэн томъёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт. Санал хураалтад 13 гишүүн оролцож, 7 гишүүн дэмжиж, 53,3 хувийн саналаар уг санал дэмжигдлээ. Хуулийн төслийн хэлэлцсэн талаарх Байнгын хорооны санал, дүгнэлтийг чуулганы нэгдсэн хуралдаанд Улсын Их Хурлын гишүүн Амартүвшин танилцуулна.

11.26 цаг

Хоёр. “Онцгой байдлын ерөнхий газрын агаараас аврах ангид нэмэлт сургалт явуулах төсөл”-ийг хэрэгжүүлэх Монгол Улсын Засгийн газар, Бүгд Найрамдах Франц Улсын Засгийн газар хоорондын Санхүүгийн хэлэлцээрийг соёрхон батлах тухай хуулийн төсөл /Засгийн газар 2023.12.20-ны өдөр өргөн мэдүүлсэн, соёрхон батлах/

Дараагийн асуудалдаа оръё.
3. ОБЕГ-ын агаараас аврах ангид нэмэлт сургалт явуулах төслийг хэрэгжүүлэх Монгол Улсын ЗГ Бүгд Найрамдах Франц Улсын ЗГ хоорондын санхүүгийн хэлэлцээрийг соёрхон батлах тухай хуулийн төслийг хэлэлцэнэ. Ажлын хэсэг өөрчлөгдөөгүй хэвээрээ байгаа. Ажлын хэсэг дээр нэмж Сангийн яамнаас хүн дуудаарай. Энэ олон улсын хэлэлцээртэй холбоотой энэ асуудал дээр Сангийн яам жоохон ач холбогдол өгнө шүү. Байнгын хороонд жоохон хүндэтгэлтэй хандана шүү. 1 мэргэжилтэн явуулчхаад суугаад байж таарахгүй шүү. Хүмүүсээ дууд. ОБЕГ-ын агаараас аврах ангид нэмэлт сургалт явуулах төслийг хэрэгжүүлэх Монгол Улсын ЗГ Бүгд Найрамдах Франц Улсын ЗГ хоорондын санхүүгийн хэлэлцээрийн төслийг зөвшилцөх асуудлыг Эдийн засгийн байнгын хороо 2023 оны 10 дугаар сарын 5-ны өдрийн хуралдаанаар хэлэлцэж, дэмжсэн санал, дүгнэлтийг ирүүлсэн.

Мөн Аюулгүй байдал, гадаад бодлогын болон Төсвийн байнгын хорооны 2023 оны 10 дугаар сарын 5-ны

өдрийн хамтарсан хуралдаанаар уг асуудлыг хэлэлцэж дэмжсэн талаарх санал, дүгнэлтээ ЗГ-т хүргүүлсэн болно. Хуулийн төслийн талаарх танилцуулгыг Монгол Улсын ЗГ-ын гишүүн, Батлан хамгаалахын сайд Гүрсэдийн Сайханбаяр танилцуулна. 2 номерын микрофоныг өгье.

Г.Сайханбаяр: Улсын Их Хурлын Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хорооны дарга эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын ЗГ Бүгд Найрамдах Франц улсын ЗГ хооронд 2019 онд байгуулсан санхүүгийн хэлэлцээрийн хүрээнд онцгой байдлын байгууллагад агаараас эрэн хайх, аврах анги байгуулах, нисдэг тэрэг нийлүүлэх төслийг амжилттай хэрэгжүүлсэн. Төслийн хүрээнд 4 нисдэг тэрэг нийлүүлэгдэж, евро стандартын симулятор, засвар үйлчилгээний төв, оффис бүхий ангартай агаараас эрэн хайх, аврах анги байгуулагдаж, нисгэгч, инженер, техникийн ажилтнуудыг бэлтгээд байна. Тус анги 2023 оны 12 дугаар сарын байдлаар нийт 94 удаагийн тусгай үүргийн нислэг үйлдэж, ослын улмаас бэртэж, гэмтсэн газраар тээвэрлэх боломжгүй нөхцөлд байсан 133 хүний амь насыг авран хамгаалж, анхан шатын тусламж үйлчилгээг шуурхай үзүүлэн ажиллаж байна.

Монгол Улсын ЗГ-аас энэ төслийн хэрэгцээ, шаардлага, ач холбогдлыг харгалзан дараагийн шатын төслийг хэрэгжүүлэхээр шийдвэрлэсний дагуу гэрээ байгуулах санал, гэрээний төслийг урьдчилан Улсын Их Хурлын Аюулгүй байдал, гадаад бодлогын болон Төсвийн байнгын хороо, Эдийн засгийн байнгын хорооны хуралдаанаар хэлэлцүүлж урьдчилан зөвшилцсөн. Монгол Улсын Ерөнхийлөгч Ухнаагийн Хүрэлсүхийн Бүгд Найрамдах Франц Улсад хийсэн төрийн айлчлалын үеэр ОБЕГ-аас Агаараас аврах ангид нэмэлт сургалт явуулах төслийг хэрэгжүүлэх санхүүгийн хэлэлцээрт Монгол Улсын Сангийн сайд Жавхлан, Бүгд найрамдах Франц Улсын

Жижигд, дунд үйлдвэр, худалдаа, аялал жуулчлалын асуудал эрхэлсэн сайд Оливия Грегуар нар 2023 оны 10 дугаар сарын 13-ны өдөр Парис хотноо харилцан гарын үсэг зурсан болно.

Энэхүү хэлэлцээрийн дагуу жилийн 0,282 хувийн хүүтэй, 20 жилийн хугацаанд 24,7 сая евротой тэнцэх хэмжээний нэн хөнгөлөлттэй зээл авах юм. Төслийн 2 дугаар шатыг хэрэгжүүлснээр Монгол Улсын онцгой байдлын байгууллагын нисгэгчид онцгой үүргийн нислэгийг өдөр шөнийн цагт хүндрүүлсэн нөхцөлд бие даан гүйцэтгэх бүрэн чадвартай болж, инженер, техникийн ажилтнуудыг үргэлжлүүлэн сургаж, нисдэг тэрэгний сэлбэг хэрэгсэл нийлүүлэх, засвар үйлчилгээ хийх арга хэмжээг хэрэгжүүлэх болно. ОБЕГ-аас, газрын агаараас аврах ангид нэмэлт сургалт явуулах төслийг хэрэгжүүлэх санхүүгийн хэлэлцээрийг соёрхон батлах хуулийн төслийг ЗГ-ын хуралдаанаар хэлэлцэн дэмжсэний дагуу Улсын Их Хуралд 2023 оны 12 дугаар сарын 20-ны өдөр өргөн мэдүүлсэн болно. Хуулийн төсөл батлагдсантай холбогдуулан цаашид шинээр боловсруулах буюу нэмэлт, өөрчлөлт оруулах, хүчингүй болгох хууль тогтоомж байхгүй болно.

Байнгын хорооны дарга, эрхэм гишүүд ээ,

ОБЕГ-ын Агаараас аврах ангид нэмэлт сургалт явуулах төслийг хэрэгжүүлэх Монгол Улсын ЗГ Бүгд Найрамдах Франц Улсын ЗГ хоорондын санхүүгийн хэлэлцээрийг соёрхон батлах тухай хуулийн төслийг хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг та бүхнээс хүсье. Анхаарал тавьсанд баярлалаа.

Б.Энх-Амгалан: Хуулийн төсөлтэй холбогдуулан асуулт асуух гишүүн байна уу. Амартүвшин гишүүнээр тасаллаа. Ганибалын Амартүвшин гишүүн асуултаа асууя. Гишүүдээ дуудаарай, одоо санал хураалт явна шүү.

Г.Амартүвшин: Баярлалаа би товчхон ганц 2 асуулт асууя. Энэ ер нь бол энэ 24,7 сая еврогийн тал хувь нь болохоор сургалтын зардал юм байна шүү дээ тийм ээ? Өөрөөр хэлбэл яг юунд зарцуулах гэж байгаа тал дээр нэг тодорхой мэдээлэл өгнө үү? 2 дугаарт миний ойлгож байгаагаар болохоор нислэгийн нисгэгчдийг сургаж байна гэж ойлгоод байгаа шүү дээ. Тийм үү, үгүй юү? Хэрвээ тийм бол нэг ийм асуудал үүсээд байгаа юм л даа. Одоо энэ евро коптоор нисдэг тэргийг чинь хувь хүмүүс ААН-үүд маш их хэмжээгээр оруулж ирээд, тэр нь сайн л даа, буруутгаж байгаа юм биш. Гэхдээ нөгөө нисгэгчдийг нь төсвийн мөнгөөр сургаад байдаг Онцгой байдлынхан. Сурангуут нь нөгөө ААН-үүд, хувь руу ороод хувийн нисдэг тэргийг жолооддог болчих вий дээ л гэсэн тийм болгоомжлол байна л даа. Тэгэхээр энэ боловсон хүчнээ яаж авч үлдэх юм, яаж урамиуулах юм, урт хугацаанд онцгой байдалд ажиллах тэр нөхцөлийг нь та нар хангаж чадах уу гэдэг дээр би асуух гэсэн юм. Баярлалаа.

Б.Энх-Амгалан: Асуултад ОБЕГ-ын дарга Ариунбуян генерал хариулъя. 3 номерын микрофоныг өгье. Энэ сургалтад 13 сая төгрөг, 13 сая евро байна энийг л асуугаад байгаа юм шүү дээ. Тэрийг тодорхой хариулаарай.

Г.Амартүвшин: Амартүвшин гишүүний асуултад хариулъя. Ингээд бэлтгэгдэж байгаа нисгэгчтэй бид нар бол хариуцлагын гэрээ буюу тогтвортой ажиллагааны гэрээгээ байгуулсан, удаан хугацаанд энд үйлчилнэ. Өөрөөр хэлэх юм бол онцгой байдлын байгууллагад ингээд сургаж бэлтгэгдэж, төсвийн хөрөнгөөр сургагдсан албан хаагч нар хувийн хэвшил рүү бол орохгүй. Орсон тохиолдолд энэ хугацааны бүх төлбөрийг хариуцна гэдэг ийм агуулгатай. Ингээд 15 жилийн хугацаатайгаар бид нар гэрээ байгуулсан байгаа. Энэ сургалт нийт төсвийн зардал бол ер нь болбол энэ онгоцны ашиглалтын үйл ажиллагаатай холбоотой зардал байгаа, давхар сэлбэгүүд нийлүүлэгдэнэ. Тухайн цаг 50,

100, 400, 800 цагийн засвар үйлчилгээнүүд хийгдэхтэй холбоотой сэлбэгүүд энд нийлүүлэгдэнэ. Аюулгүй ажиллагааны засвар үйлчилгээ бас орж байгаа. Тээвэр логистикийн ачаа тээврийн зардал мөн ордог. Мөн манай дээр ашиглагдаж байгаа симулятор буюу дадлагажуурын ашиглалттай холбоотой зардал гээд ийм ашиглалтын зардлууд нэлээн орно. Дээр нь энэ нисэх ангийн үйл ажиллагааны бас зардал бас тодорхой хэмжээгээр санхүүжигдэж явна.

Мөн сургалттай холбоотой гадаадаас ирж ажиллаж байгаа мэргэжилтэн багш нарын цалин хөлс, энд байрлах томилолтын зардал мөн манай нисгэгч, инженер техникийн ажилтнууд Францад улсад ижил төстэй байгууллагуудад буюу баазуудад сургалтад хамрагдах энэ зардлууд мөн орно. Эмч, сувилагч, инженерүүдийг бас бэлтгэх ийм зардлууд энэ төсөлд орсон байгаа юм.

Б.Энх-Амгалан: Амартүвшин гишүүн тодруулъя.

Г.Амартүвшин: Яах вэ тогтвортой гэрээ зураад ингэж тэр нисгэгчдээ авч үлдэх тийм юу байдаг л даа. Зүгээр би банканд банкны захирал байхад бид нар бас тийм *popcompete* ингээд гэрээ зурж л байсан юм. Тэр бол тээгээд шүүх дээр очоод л уначихдаг л юм байна лээ л дээ. Тэгэхээр илүү урт хугацааны шийдэл нь болохоор тэр нисгэгчдээ бол хангалттай өрсөлдөхүйц хэмжээний цалин өгөх л байгаа юм л даа. Нөгөө хувийн хэвшил рүү гүйгээд байхгүйн тулд. Тэгэхээр тэрэн дээр та нар анхаарна биз дээ. Энэ асуулт биш зүгээр л үг хэлсэн юм.

Б.Энх-Амгалан: Нэмж хариулах уу? Онцгой байдлын дарга энэ 13 сая евро болбол бас их мөнгө шүү дээ. Тэгээд ийм их мөнгөөр зөвхөн ингээд Францчуудыг авчраад л, байрлуулаад л, хоолыг нь өгөөд л нөгөө манай нэг зээлийн нэг хэсэг нь ингээд нөгөө сургалт, тоног төхөөрөмж

нийлүүлэх, цалин гээд ингээд тодорхой хэсэг нь буцаад гараад явчихдаг. Яг нэг боингийн нисгэгч бэлтгэхэд 100 мянган доллар л байхгүй юу. Тэгэхээр зэрэг ийм их мөнгөөр чинь ингээд хэдэн хүн сургах гэж байгаа юм бэ? Нэг эсвэл нисдэг тэрэгний арми байгуулах гэж байгаа юм шиг ингээд яваад байна гэдгийг хүмүүс хэлээд байна шүү дээ. Энэ дээр нэг тодорхой хариулаадхаач.

Г.Ариунбуян: Агаараас эрэн хайх, аврах ангид нисгэгч нарыг сургах энэ сургалтын төсөлд нийт 12 нисгэгч, 12 инженер техникийн ажилтан, дээр нь эмч, сувилагч, аврах ажиллагааны мэргэжилтэн гээд үндсэндээ 30 гаруй албан хаагчийг сургаж бэлдэнэ. Өнөөдөр өнгөрсөн төслийн хугацаанд манай нисгэгч нар 100 цагийн лицензтэй туршлагатай болсон. Олон улсад мөрдөгдөж байгаа энэ стандартаар онцгой үүргийн нислэг үйлддэг онцгой байдлын албаны нисгэгч нар доод тал нь 2 мянган цаг ниссэн байх туршлагатай байдаг. Тэгэхээр бид энэ төслийн хугацаанд доод тал нь 500 цагийн нислэгийн цагтай болох өөрөөр хэлэх юм бол ямар ч цаг мөчид өөрөөр хэлэх юм бол ердийн болон хүндрүүлсэн нөхцөлд үүрэг гүйцэтгэх ийм чадавх болох ийм үндэсний боловсон хүчнийг бэлтгэхээрээ ач холбогдолтой байгаа юм. Дээр нь аврах ажиллагааны мэргэжилтнүүдээ бид бэлдэнэ. Инженер техникийн ажилтнууд 12 хүнээ бид нар энэ нисдэг тэрэгний хөдөлгүүрийг бүрэн задалдаг, угсардаг ийм боломжтой болж авна. Тэгээд цаашилаад мэдээж энэ төсөл дууссаны дараа хувийн хэвшлийн EC-145 загварын нисдэг тэргийг бид нар дотооддоо засварлах, үйлчилгээ хийх ийм чадавхтай боловсон хүчнийг бэлдэж байгаагаараа их ач холбогдолтой юм. Ач холбогдолтой байгаа. Ингээд энэ зардлын хувьд бол дийлэнх нь сургалт, мөн сэлбэг хэрэгсэл бас энд дагалдаж нийлүүлэгдэж байгаа. Дээр би түрүүн хэлсэн тодорхой цагийн засвар үйлчилгээнүүдийг хийхтэй холбоотой бас урсгал зардлууд бас энд давхар тусгагдсан. Францад очиж манайхан

сургалтад хамрагдах энэ бас зардлууд бас энд хамрагдаж байгаа.

Б.Энх-Амгалан: Ойлголоо. Гишүүд асуулт авч, хариулт авч дууслаа. Асуулт асууж, хариулт авч дууслаа. Генералаа нэг юм анхаараарай. Наадах чинь 40-өөд хүн сургахын тулд нэг хүнд 50 тэрбум төгрөг гарч байна шүү. Тэгээд та сая бол түүн дотор нь сэлбэг хэрэгсэл, тоног төхөөрөмж байгаа гэж хэллээ. Тэгвэл тэрийгээ ард нь тодорхойлж, тэдэн хувь нь тоног төхөөрөмж, сэлбэг хэрэгсэл байгаа юм гэхгүй болбол нэг хүнийг 50 тэрбумаар сургана гээд ороод ирэх юм бол наадах чинь бол асуудал болно шүү. Ойлголоо. Ингээд хуулийн төсөлтэй холбогдуулан үг хэлэх гишүүд байна уу? Алга байна.

Санал хураалт явуулъя. ОБЕГ-ын Агаараас аврах ангид нэмэлт сургалт явуулах төслийг хэрэгжүүлэх Монгол Улсын ЗГ Бүгд Найрамдах Франц Улсын ЗГ хоорондын санхүүгийн хэлэлцээрийг соёрхон батлах тухай хуулийн төслийг дэмжье гэсэн томъёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт. 13 гишүүн санал хураалтад оролцож, 9 гишүүн дэмжиж, 69,2 хувиар уг санал дэмжигдлээ. Хуулийн төслийн хэлэлцсэн талаарх Байнгын хорооны санал, дүгнэлтийг чуулганы нэгдсэн хуралдаанд Улсын Их Хурлын гишүүн Амартүвшин танилцуулна. Ажлын хэсэгт баярлалаа.

11.39 цаг

Гурав. Байнгын хорооны тогтоолын төсөл /Улсын Их Хурлын 2023 оны намрын ээлжит чуулганы 2024 оны 01 дүгээр сард Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хорооны хэлэлцэх асуудлын цаглавар батлах тухай/

Дараагийн асуудалдаа оръё. Монгол Улсын Их Хурлын 2023 оны намрын ээлжит чуулганы 2024 оны 1 дүгээр сард Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хорооны хэлэлцэх асуудлын цаглавар батлах тухай Байнгын хорооны тогтоолын төслийг

хэлэлцэнэ. Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 10.6-д энэ хуулийн 10.5-д заасан дарааллыг үндэслэн хэлэлцэх асуудлын цаглаварыг Байнгын хороод баталж мөрдүүлнэ. 10.5-д ээлжит чуулганаар хэлэлцэх асуудлыг баталсан Улсын Их Хурлын тогтоолд заасан хууль тогтоомжийн, хууль, тогтоолын төслийн хэлэлцэх дарааллыг Зөвлөлийн саналыг харгалзан Улсын Их Хурлын дарга сар бүр захирамжаар батална гэж тус тус бас заасан. Тогтоолын төслийг гишүүдэд тараасан байгаа.

Тогтоолын төслийг та бүхэнд уншиж танилцуулъя. Монгол Улсын Их Хурлын 2023 оны намрын ээлжит чуулганы 24 оны 01 дүгээр сард Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хорооны хэлэлцэх асуудлын цаглавар батлах тухай. Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.2.14 дэх заалт, Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.6 дахь хэсгийг үндэслэн Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хорооноос тогтоох нь.

1. Монгол Улсын Их Хурлын даргын 2023 оны 12 дугаар сарын 27-ны өдрийн Монгол Улсын Их Хурлын 2023 оны намрын ээлжит ээлжит чуулганы 2024 оны 1 дүгээр сард хэлэлцэх асуудлын дараалал тогтоох тухай 221 дүгээр захирамжид заасан Аюулгүй байдал, гадаад бодлогын Байнгын хорооны эрхлэх асуудлын хүрээнд хамаарах хууль, Улсын Их Хурлын бусад шийдвэрийн төслийг хэлэлцэх цаглаварыг хавсралтаар баталсугай.

2. Хэлэлцэх хугацааг хуульд тусгайлан заасан болон бусад Байнгын хорооны эрхлэх асуудлын хүрээнд өргөн мэдүүлсэн хууль, Улсын Их Хурлын бусад шийдвэрийн төсөлтэй хамт өргөн мэдүүлсэн Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хорооны эрхлэх асуудлын хүрээний хууль, Улсын Их

Хурлын бусад шийдвэрийн төслийг хэлэлцэхэд энэ цаглавар хамаарахгүй.

3.Энэ тогтоолын биелэлтийг хангаж ажиллахыг Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хорооны хороо Энх-Амгаланд, хэлэлцэх асуудлын бэлтгэл хангах, мэргэжил арга зүйн зохион байгуулалтын тусалцаа үзүүлэхийг Улсын Их Хурлын Тамгын газар Энхбатад үүрэг болгосугай гэсэн ийм тогтоолын төсөл байна. Тогтоолын төсөлтэй холбогдуулан асуулт асууж, үг хэлэх гишүүд байна уу? Алга байна. Тэгвэл тогтоолын төсөлтэй холбогдуулан гишүүд асуулт асууж, үг хэлж дууслаа.

Санал хураалт явуулъя. Монгол Улсын Их Хурлын 2023 оны намрын ээлжит чуулганы 2024 оны 1 дүгээр сард Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хорооны хэлэлцэх асуудлын цаглавар батлах тухай Байнгын хорооны тогтоолын төслийг баталъя гэсэн томъёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт. Санал хураалтад 13 гишүүн оролцож, 9 гишүүн дэмжиж, 69,2 хувиар уг санал дэмжигдлээ. Байнгын хорооны тогтоол батлагдлаа.

11.41 цаг

Дөрөв.Элчин сайд нарыг эгүүлэн татах, томилох асуудлаар зөвшилцөх тухай /Монгол Улсын Ерөнхийлөгчөөс 2024.01.09-ний өдөр өргөн мэдүүлсэн, зөвшилцөх/

Дараагийн асуудалдаа оръё. Бусад асуудлын хүрээнд 2 асуудал хэлэлцэнэ. 1.Элчин сайд нарыг эгүүлэн татах, томилох асуудлаар зөвшилцөх тухай асуудлыг хэлэлцэнэ. Монгол Улсын Ерөнхийлөгч 2024 оны 1 сарын 5-ны өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн. Хуралдаанд оролцох Ажлын хэсгийн гишүүдийг оролцуулъя. Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 106.1-д Монгол Улсын Ерөнхийлөгч гадаад улсад суух Элчин сайд, Бүрэн эрхт төлөөлөгчийн газрын

тэргүүнийг томилох, эгүүлэн татах саналыг Улсын Их Хуралд зөвшилцөхөөр өргөн мэдүүлсэн бол тухайн саналыг 72 цагийн дотор Улсын Их Хурлын гишүүдэд хургуулна. Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хороо ийнхүү хургуулснаас хойш ажлын 3 өдрийн дараа тухайн саналыг хэлэлцэж, санал, дүгнэлт гаргана. Хэрэв нэр дэвшигчийн сонсгол явуулах санал гарсан бол сонсголын тайлан гаргаснаас хойш ажлын 5 өдрийн дотор Байнгын хороо хэлэлцэж санал, дүгнэлт гаргана. Санал, дүгнэлтэд сонсголын тайлангийн агуулгыг өөрчлөхгүйгээр тусгана гэж заасан.

Хуралдаанд оролцож байгаа ажлын хэсгийн гишүүдийг танилцуулъя. Монгол Улсын Ерөнхийлөгчийн Үндэсний аюулгүй байдал, улс төрийн бодлогын зөвлөх Жадамбын Энхбаяр, Гадаад харилцааны яам Монгол Улсын ЗГ-ын гишүүн, Гадаад харилцааны сайд Батмөнхийн Батцэцэг, Гүнтэвийн Бямбасүрэн мөн яамны Бодлого, төлөвлөлтийн газрын захирал, Дашпүрэвийн Амарсайхан тус яамны Төрийн захиргаа, удирдлагын газрын захирал, Бат-Очирын Болд мөн яамны Консулын газрын захирал. Хуралдаанд мөн Монгол Улсаас гадаад улсад суух Элчин сайдаар томилогдох албан тушаалтнуудыг танилцуулъя. Саналаар орж ирж байна. 1.Сүхээгийн Сүхболд Монгол Улсаас Бүгд Найрамдах Солонгос улсад суух Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин сайдаар, 2.Гунаажавын Байгалмаа Монгол Улсаас Польш улсад суух Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин сайдаар, 3.Цэрэндоржийн Мөнх-Өлзий Монгол Улсаас Шведийн Хаант улсад суух Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин сайдаар, 4.Нямдоржийн Анхбаяр Монгол Улсаас Нэгдсэн Үндэстний Байгууллагын дэргэд суух байнгын төлөөлөгчөөр. Тараагаад өгчихсөн шүү дээ. Гишүүдэд тарааж өгсөн, дутуу байгаа бол нэмж өгөөрэй.

Монгол Улсад гадаад улсад суух Элчин сайд нарыг эргүүлэн татах, томилох асуудлыг зөвшилцөхөөр 2024

оны 01 дүгээр сарын 5-ны өдөр Улсын Их Хуралд ирүүлсэн Монгол Улсын Ерөнхийлөгчийн саналыг Монгол Улсын Ерөнхийлөгчийн Үндэсний аюулгүй байдал, улс төрийн бодлогын зөвлөх Жадамбын Энхбаяр танилцуулна. Энхбаяр даргын микрофоныг өгье. 2 номерын микрофон.

Ж.Энхбаяр: Эрхэм хүндэт Улсын Их Хурлын Байнгын хороон дарга, эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Үндсэн хуулийн 33 дугаар зүйлийн нэг дэх хэсгийн 5 дахь заалт, Монгол Улсын Ерөнхийлөгчийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 3, ЗГ-ын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 4, Дипломат албаны тухай хуулийн 16 дугаар зүйлийн нэг дэх заалтыг тус тус үндэслэн, 1.Монгол Улсаас БНСУ-д суух Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин сайдаар Сүхээгийн Сүхболдыг, 2.Монгол Улсаас БНПУ-д суугаа Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин сайд Бархасын Доржийг эгүүлэн татаж, Монгол Улсаас БНПУ-д суух Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин сайдаар Гунаажавын Байгалмааг, 3.Монгол Улсаас Шведийн Хаант улсад суугаа Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин сайд Түвдэндоржийн Жанабазарыг эргүүлэн татаж, Монгол Улсаас Шведийн Хаант Улсад суух Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин сайдаар Цэрэндоржийн Мөнх-Өлзийг, 4.Монгол Улсаас НҮБ-ын дэргэд суугаа Байнгын төлөөлөгчийн байнгын төлөөлөгч Воршиловын Энхболдыг эгүүлэн татаж, Монгол Улсаас НҮБ-ын дэргэд суух Байнгын төлөөлөгчөөр Нямдоржийн Анхбаяр нарыг тус тус шинээр томилох саналыг зөвшилцөхөөр танилцуулж байна.

Элчин сайд, Байнгын төлөөлөгч нь Монгол Улсын олон улсын гэрээ, холбогдох хууль тогтоомжоор олгогдсон бүрэн эрх, хүлээсэн чиг үүргийнхээ хүрээнд суугаа болон хавсран суугаа улс, ОУБ-даа Монгол Улсыг төлөөлөн ажиллаж, ашиг сонирхол болон эрхийг нь хамгаалах харилцаа, хамтын ажиллагааг хөгжүүлэх, Монгол Улсын хөгжлийн

зорилтыг шийдвэрлэхэд шаардагдах судалгааг хийж, төр, засгийн байгууллагуудыг мэдээллээр хангах, гарсан шийдвэрийг хэрэгжүүлэх, хоёр болон олон талын харилцааны асуудлаар яриа, хэлэлцээр хийх, гэрээ, хэлэлцээр байгуулах, Монгол Улсын иргэн, хуулийн этгээдийн хууль ёсны эрх ашгийг, сонирхлыг олон улсын эрх зүй, суугаа орны хууль тогтоомжийн дагуу хамгаалж ажилладгаас гадна, тэргүүлж буй Дипломат төлөөлөгчийнхөө газрын үйл ажиллагааг нэгдсэн удирдлагаар хангах чиг үүрэгтэй байдаг.

Элчин сайд, Байнгын төлөөлөгчөөр томилон ажиллуулахаар нэр дэвшүүлж буй эдгээр албан хаагчид нь төрийн алба, дипломат албанд олон жил ажилласан, мэргэжлийн өндөр ур чадвартай, удирдах ажлын дадлага туршилагатай, гадаад хэлний мэдлэгтэй, төрийн болон дипломат албаны хууль тогтоомжийн шалгуурыг хангасан, төрийн тусгай албанд ажиллах бүрэн боломжтой албан хаагчид болно. Иймд дээрх орнуудад суугаа Элчин сайд, НҮБ-ын дэргэд суугаа байнгын төлөөлөгчийг эгүүлэн татах, шинээр томилох Монгол Улсын Ерөнхийлөгч Ухнаагийн Хүрэлсүхийн саналыг зөвшилцөн шийдвэрлэж өгөхийг хүсье. Анхаарал тавьсанд баярлалаа.

Б.Энх-Амгалан: Энхбаяр даргад баярлалаа. Монгол Улсын Ерөнхийлөгчийн санал болон нэр дэвшигчтэй холбогдуулан үг хэлэх, асуулт асуух гишүүд байна уу? Асуулт тусдаа, үг нь тусдаа. Асуулт тусдаа. Ганбат гишүүнээр тасаллаа. Цогтбаатар гишүүн нэрээ татлаа, үг хэлэхээр боллоо. Баттөмөр гишүүн, гишүүд. Тэгвэл, Ганбат гишүүн асуултаа асууя.

Д.Ганбат: Ерөнхийдөө бол өнгөрсөн жилүүдэд манай гадаад харилцаа бол их сайн байгаа, дажгүй байгаа гэж хэлнэ. Ялангуяа энэ гуравдагч хөрийн бодлогыг бол нэлээн сайн явууллаа. Тэр манай Монгол Улсын

ерөнхийлөгч Английн хааны тэр залах ёслолд оролцлоо. Бас Францад Ерөнхийлөгчийн айлчлалыг их амжилттай сайн зохион байгууллаа гэж үзэж байна. Өнөөдрийн орж ирж байгаа 3 элчин сайдын хувьд бол боломжийн байна гэж дүгнэж байна, 4 үү? Уучлаарай 4 Элчин сайд бол сая анкетыг нь харлаа л даа. Ер нь ажил төрлийн хуваарь ч гэсэн ер нь ихэнх нь мэдэх юм байна. Боломжийн улсууд оруулж ирсэн байна. Өнөөдрийн тавьж байгаа шаардлагыг хангахуйцаар.

Бас яах вэ хэд хэдэн асуулт байна. Сүүлийн 8 жил 2015, 2016 онд чөлөөт худалдааны гэрээ бол Япон улстай бид нар байгуулж чадсан, бараг анхны гэрээ байх. Тэрнээс хойш бол энэ чөлөөт худалдааны гэрээ нэг их сайн хийгдэхгүй байна. Энэ тал дээр бүгдээрээ л Гадаад явдлын яаманд ажиллаж байгаад л явж байгаа улсууд байна. Солонгостой бол ярилцаж байгаа гэсэн мэдээлэл байгаа ЕРА, нэн шаардлагатай энэ иж бүрэн стратегийн түншлэлийн хэмжээнд байгаа 2 хөри байгаа. Бид нар чинь 2 том хөршөөр л хүрээлэгдсэн ийм улс байгаа шүү дээ. Энэ 2 хөрштэйгөө бас байгуулах ёстой. Энэ ардчилсан улс орнууд Солонгос, энэ боломжтой Европын холбооны улс энэ тэр гээд байгуулах шаардлагатай ийм шаардлага байна л даа. Яагаад вэ гэхээр бид нар чинь энэ 2 улсыг даваад, баахан ачаа тээвэр энэ бүх юм чинь аягүй их өндөр өртөгтэй байна. Бид нар чинь үйлдвэрлэгч техник технологийн хувьд тийм сайн биш байна шүү дээ. Энэ талаар нөхдүүд юу бодож байна вэ? Энэ тал дээр бол нэлээн хоцрогдож байна.

Өмнө нь 4 газар ажиллаж байсан Элчин сайдууд байгаа. Энэ хүмүүсийнхээ тайлан юм хум нь ямар байгаа вэ? Хэр зэрэг амжилттай ажиллаад ирсэн бэ? Ер нь цаашидаа тэр хөрөнгө оруулалт татах, жуулчдыг татах энэ бүх юманд анхаарч ажиллах ёстой. Энэ явж байгаа улсуудын элчин, улс орнуудад бол Швейцар байна, Солонгос байна, манай иргэд их хэмжээгээр ажиллаж байгаа.

Шведэд, Шведэд, АНУ-д ч гэсэн Ньюйоркт ч гэсэн ажиллаж байгаа гэж бодож байна. Польшид ч гэсэн байгаа. Тэгэхээр энэ тал дээр та бүхэн ямар анхаарал тавьж, яаж ажиллах юм бэ? Аль болохоор уг нь бид нар бол энэ ардчилсан улс орнуудтай визгүй болох ёстой. Энэ тал дээр бас зарим нэг улс орнуудтай гайгүй ажиллаж байгаа гэсэн ийм ойлголт байгаа. Нэлээн хэд хэдэн орон нэмэгдсэн байх. Монгол паспорт арай дээрдэж байна. Гэхдээ шаардлагын хэмжээнд хүрэхгүй байгаа.

Ялангуяа Солонгос улстай бол уг нь бол Солонгосын Элчин сайдтай бол, Солонгосын зохих албаны хүмүүстэй уулзахаараа миний зүгээс бол байнга л ярьж байгаа. Манай иргэд бол чөлөөтэй зорчоод ингээд эхлэх юм бол харилцан визгүй болчих юм бол бид нарын хувьд бол Солонгост тэгээд л насаараа үлдээд байх ийм улсууд биш. Өнөөдөр аргагүй байдлаас болоод л энэ хүмүүс ингэж ажил төрөл хийх гэж явж байна гэдэг ийм зүйлийг хэлж байгаа. Цаашидаа та бүхэн энэ талаар яаж анхаарч ажиллах гэж байна вэ гэсэн ийм хэдэн асуултууд байна.

Б.Энх-Амгалан: Эхний асуултад Батцэцэг сайд хариулъя, 3 номерын микрофон. Тэгээд дараад нь сайд нар хариулна.

Б.Батцэцэг: Баярлалаа. Тэгээд Ганбат гишүүний асуултад хариулъя. Бидний ажлыг бас үнэлж үнэлэлт өгч байгаад бас талархлаа илэрхийлье. Тэгээд Монгол Улс яах вэ чөлөөт худалдааны хэлэлцээрийг анх Япон улстай байгуулсан 2015 онд, 16 онд. Энэ бол манай хувьд анхных нь хэлэлцээр. Европын холбооноос бас сайн засаглал, тогтвортой хөгжлийн болзлыг хангасан хөгжиж байгаа орнуудад хэрэгжүүлдэг хөнгөлөлттэй ерөнхий систем GSP plus-ийн Монгол Улсад олгодог тарифын хөнгөлөлтийг бас 2027 он хүртэл сунгахаар шийдвэрлэсэн. Дараа нь Ази Номхон далайн худалдааны хэлэлцээр буюу АПТА-д Монгол Улс 2020 онд

элссэн, нэгдэж орсон. 21 оны 1 дүгээр сараас эхлээд хэрэгжүүлж байгаа. Одоо Солонгос Улстай бид нар бас судалгааны ажлыг 16 оноос эхлээд хийгээд, одоо хэлэлцээ хийх шатдаа орсон, 12 сард эхний хэлэлцээгээ болбол хийсэн байгаа. Тэгэхээр энэ Солонгостой хийх чөлөөт худалдааны хэлэлцээрийг Эдийн засгийн хөгжлийн яам хариуцаж ажиллаж байгаа. Нэлээн идэвхтэй яриа хэлэлцээнүүд, байнгын механизмууд ажиллаж байгаа.

2 дахь асуултын хувьд Элчин сайд нарын ажлын үр дүнгийн талаар бас хамгийн сүүлд 23 Элчин сайд нэмэх нь 6 гээд нийтдээ 29, 30-аад Элчин сайд сүүлийн 2 жил томилогдсон. Элчин сайд нартай бүгдтэй нь сайдын хувьд бас тусгайлан гэрээ байгуулж явуулж байгаа. Тэр нь 5 зүйл заалттай. Энэ нь бол 1 дүгээрт нь мэдээж иргэдийн асуудал, 2 дугаарт нь эдийн засгийн асуудал, худалдаа, хөрөнгө оруулалт татах чиглэлээр ахиц дэвшил гаргах, 3 дугаарт нь тухайн орон тоо хоёр талын болон олон талын харилцаагаараа шат ахиулах ийм Элчин сайд нарын өөрсдийнх нь судалж хэлсний саналынх нь дагуу гэрээнүүд байгуулсан. Дүгнэж байгаа эхний жилийн дүгнэлт буюу 2022 оны жилийн эцсээр дүгнэхэд болбол тийм төдийлөн үр дүнтэй тайлангууд бас байгаагүй. Гэхдээ болбол олон газар ахиц гарсан, хөрөнгө оруулалт нэмэгдсэн, олон баримт бичиг байгуулсан, иргэдийнхээ асуудалд ингэж анхаарсан гээд нэлээн, 23 оны жилийн эцсийнхийг сая бид нар одоо дүгнэж байна. Түрүүчээсээ гарсан. Энэ дээр бол нэлээн ахиц дэвшилүүд гарч, энэ дүгнэлтүүдийг нь би бас Гадаад бодлогын байнгын хороондоо бас явуулъя гэж бодож байгаа.

Энэ олон айлчлалууд бас хэрэгжүүлсэн газрууд дээр нэлээн ахиц дэвшилүүд гарсан. Хөрөнгө оруулалтыг бас бид нар улс бүрээр нь, Элчин сайд болгоноор өөрийнх нь гаргаж байгаа улсаас тухайн ЭСЯ-нд гаргаж байгаа зардалтай нь харьцуулаад бас судалгаа хийсэн дүгнэлт гарсан байгаа. Элчин

сайд тус бүрийн ажлыг нь дүгнэж, тодорхой үзүүлэлтээр бас шалгаруулж байр эзлүүлсэн. Хөрөнгө оруулалт татах, тэгээд эдийн засаг худалдааны чиглэлээр ажилласан, ААН компаниудаа хэрхэн дэмжиж ажилласан, иргэдийн асуудлыг яаж шийдсэн, иргэдийн санаачилгаар хийж байгаа арга хэмжээнүүд болон иргэд төрийн бус байгууллагуудтай хэрхэн ажилласан мөн иргэдийн төрийн үйлчилгээ авах болон цахим үйлчилгээ болон бусад нотариатын үйлчилгээ зэргийг цахимжуулснаар нэлээд ийм ахиц дэвшилүүд гарсан ийм үзүүлэлтүүд гарч байгаа. Тэгээд энэ нэлээн их мэдээлэл байгаа учраас би жич хүргүүлье. Хэрэгтэй бол.

Иргэдийн асуудлыг би бас сая цухас дурдлаа. Нийтдээ бараг 200-гаад, 200 орчим мянган Монгол иргэд 90 улс оронд ажиллаж, амьдарч байна. Тэдний маань санаачилгаар нийтдээ 150-аад ТББ байдаг. Тэрэн дотроо 30, 40 ТББ бол маш идэвхтэй ажилладаг. Дипломат төлөөлөгчийн газар байдаг улс орнуудад болбол эрчимтэй нэлээн дэмжлэг сайтай ажилладаг. Дипломат төлөөлөгчийн газар байдаггүй орнуудад иргэд цөөхөн байдаг учраас бүс нутагтаа буюу ингээд олон улсын хэмжээнд бас төрийн бус байгууллагууд нийлээд олон ийм санал санаачилгууд гаргах, тэмцээн.../минут дуусав/

Б.Энх-Амгалан: Гүйцээгээд хариулъя, 3 номерын микрофоныг нэмж өгье.

Б.Батцэцэг: Ажлуудыг нь болбол ЭСЯ-дууд дэмжиж байгаа. Зүгээр ер нь урьд өмнөх жилүүдтэй харьцуулахад бид нар бас тодорхой хэмжээний бага сага төсвийг бол шийдэж өгч байгаа. Энэ төрийн бус байгууллагуудын санал санаачилгаар хийж байгаа хурал цуглаан, семинар арга хэмжээ, баяр ёслол, тэмцээн уралдаан дэмжиж байгаа. Тэгэхээр хилийн чанадад байгаа төрийн бус байгууллагууд нэгдээд манай яам дээр бас ажлын өрөөтэй болсон. Төлөөлөл нь

буюу холбооных нь тэргүүлэгчид бас ажилладаг. Яамны сайдын зөвлөлийн дэргэд бас Ёс зүйн хороо ажилладаг. Иргэдээс ирж байгаа гомдлыг барагдуулах чиглэлээр нэлээн ажиллаж байгаа. Өнгөрсөн жил бас бид нар хурдан гээд системийг 19 оронд суурилуулсан. Нотариатын үйлчилгээг 100 хувь цахим болгосон. Энэ бас хилийн чанадад сууж байгаа иргэдэд бас их сэтгэлд нь нийцэж байгаа ажил болсон.

Визийн тухайд бид нар энэ жил нэлээн олон оронтой визгүй зорчих хэлэлцээр байгуулсан. Нийтдээ бид нар Грек, Славян, Перу, Индонези, Австрали, Узбекистан, Мальдив, Португал, Вьетнам, Чех, АНЭУ-тай бид нар албан дипломат болон энгийн паспорт эзэмшигчдийг визийн шаардлагаас чөлөөлөх тухай хэлэлцээрийг байгуулсан. Энэ саяын дурдсан 11 улсаас тал нь энгийн бүх паспортод хамаарагдана. Тал нь албан дипломат паспортод хамаарагдаж байгаа. 2024 онд бид нар одоо хэлэлцээд явж байгаа, дахиад энэ ондоо 24 онд багтаагаад байгуулах бас 10 энэ хэлэлцээр байгаа юм. Нийтдээ ингэснээрээ бид нар энгийн паспорттой иргэд 30 оронд визгүй, албан дипломат паспорттой иргэд 60 гаруй оронд визгүй зорчихоор болж байгаа юм.

Солонгостой визгүй болох асуудлыг бид нар бүхий л түвшинд ярьж байгаа. Мэдээж манай бас ганцхан Монгол Улсад зориулсан шийдвэр гаргаж, гаргах боломжгүй гэдгээ бас илэрхийлдэг. Яагаад гэвэл манайхтай адил төстэй хууль ёсоор, хууль бусаар оршин суудаг олон орны иргэд байдаг. Тэд нартаа зориулсан нэгдсэн бодлого баримталдгаа Солонгосын ЗГ илэрхийлдэг. Хууль зүйн яам нь. Бид болбол ямар нэгэн шатлалтайгаар визний хөнгөлөлт авъя гэдэг зүйлийг ярьж байгаа. Тэгээд өндөр дээд хэмжээний айлчлалуудын үеэр ярьсан ажлынхаа араас хөөцөлдөөд бас тодорхой дэвшилүүд бол гарсан, өвчтэй, эмчилгээний зорилгоор явж байгаа улсуудыг гэр бүлээр нь визээс чөлөөлөх,

олон удаагийн виз олгох, тэгээд юу гэрээт ажилчдын тоог нэмэгдүүлэх, хил дээрээс буцаж байгаа асуудлыг бас бид нар байнга тавьдаг. Ихэнх манайд татгалзаж байгаа шалтгаан буюу хил дээрээс буцаж байгаа шалтгаан нь манай иргэдээс өөрсдөөс нь бас их болж байгаа. Мэдээлэлгүй, визэндээ буруу материал өгдөг, хүнээр бөглүүлдэг, тэр асуулга дээр байгаа зүйлүүдээ мэдүүлж виз авчхаад, яг хил дээр очоод гарахдаа тэрийгээ өөрөө мэддэггүй ч юм уу, тэр тодорхой айлын дүрэм журмыг зөрчсөн тохиолдолд буцааж байгаа гэдгээ болбол тайлбарладаг. Ер нь болбол Солонгосын ЗГ 23 онд хууль бусаар оршин сууж байгаа иргэдийнхээ тодорхой хувийг буюу нэлээд хувийг нь бас багасгах ийм бодлого явуулсан. Тэр хүрээндээ болбол гаднын иргэдийг нэлээн буцаасан. Тэрэн дотроо болбол Монгол иргэдэд харьцангуй зөөлөн хөнгөн хандаж, юу болж өгвөл буцаахгүй байх ийм арга хэмжээнүүдийг бол авсан.

Б.Энх-Амгалан: Баярлалаа. Асуултад нэмээд Монгол Улсаас БНСУ-д суух Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин сайдад нэр дэвшигч Сүхээгийн Сүхболд хариульа.

С.Сүхболд: Ганбат гишүүний асуултад хариульа. Чөлөөт худалдааны хэлэлцээртэй холбогдуулаад Солонгосын талтай өнгөрсөн 2016 оноос хойш яриа хэлэлцээ өрнүүлээд явж байгаа. Бодитой яриа хэлэлцээ бол өнгөрсөн оны 2 дугаар сард Монгол Улсын Ерөнхий сайдын Солонгос улсад хийсэн айлчлалын хүрээнд Эдийн засгийн түншлэлийн хэлэлцээрийг эхлүүлэх хамтарсан мэдэгдэлд гарын үсэг зурсан. Үүний дараа бол эдийн засгийн түншлэлийн хэлэлцээрийн ажлын даалгаврын төслийг 9 сард ажлын хэсгийн ахлагч нар Улаанбаатар хотноо гарын үсэг зурсан. Ингээд эдийн засгийн түншлэлийн хэлэлцээрийн албан ёсны яриа хэлэлцээ бол эхэлсэн, 14 бүлэг асуудал байгаа. Миний бие одоогийн Олон улсын гэрээ, эрх зүйн газрын захирлын хувиар нэг бүлгийг бол ахалж ажиллаж байгаа. Ингээд өнгөрсөн оны

12 дугаар сарын 18-наас 20-нд Солонгост бид нар анхны хэлэлцээгээ хийсэн. Үргэлжлүүлээд дараагийн хэлэлцээг 3 сар орчимд бол хийхээр урьдчилсан байдлаар яриа хэлэлцээ явагдаж байгаа. Тийм болохоор миний бие хэрэв томилогдох аваас энэ хэлэлцээг үргэлжлүүлж дуусгах ийм чиглэлтэй ажиллана гэж төлөвлөж байгаа.

2 дугаарт Солонгост байгаа иргэдийн хувьд бол асуусан. Одоогийн Солонгос улсын Хууль зүйн яамны Цагаачлалын албанаас өгч байгаа мэдээллээр бол өнгөрсөн оны 11 дүгээр сарын 31-ний байдлаар бол 54394 иргэн байна гэсэн мэдээлэл байгаа. Үүнээс гол анхаарал татах иргэд бол визийн хугацаа болон зориулалтыг зориулалтын бусаар оршин сууж байгаа гэсэн иргэдийн тоо бол 19 мянга орчим байгаа. Тэгэхээр гол асуудал бол Солонгосын Солонгост суугаа манай ЭСЯ болон Консулын хэлтэс бол энэ иргэдтэйгээ нэг бүрчлэн түлж ажиллах, тэдний хууль ёсны эрх ашгийг хангах чиглэлээр бол зайлиггүй ажиллана гэсэн ийм бодолтой байгаа.

Түрүүн Гадаад харилцааны сайд бас хэлсэн. Визгүй хэлэлцээрийн хувьд бол 2019 оноос хойш бол визний нөхцөлийг хөнгөвчлөх хэлэлцээрүүд бол нэлээн байгуулагдаж ирж байгаа. Одоогийн байдлаар бол 29 оронд энгийн гадаад паспорттой иргэд визгүй зорчино, 61 оронд дипломат албан паспорттой иргэд, 66 онд дипломат паспорттой иргэд визгүй зорчих ийм нөхцөл нь бүрдчихээд байж байгаа. Түрүүн сайдын хэлснээр энэ онд багтаагаад дахин 10 орчим оронд визгүй зорчих хэлэлцээрийг байгуулахаар ажиллаж байна.

Б.Энх-Амгалан: Баярлалаа. Элчин сайдад нэр дэвшигч нар маш тодорхой яг асуусан асуултад хариулаарай. Энэ визний асуудал, гадаад худалдааг солонгоруулах тухай асуудал мөн иргэдийнхээ эрх ашгийг хамгаалах асуудал дээр голлон юм асуусан учраас яг тэрэнд нь хариулаарай. Монгол Улсаас БНПУ-д суух Элчин сайдад нэр дэвшигч

Гунаажавын Байгалмаа асуултад хариулъя. 1 номерын микрофон.

Г.Байгалмаа: Ганбат гишүүний асуултад хариулъя. Монгол Улс Польш Улсын хооронд худалдаа, эдийн засгийн хамтын ажиллагаа, хөрөнгө оруулалтын хамтын ажиллагаа сүүлийн жилүүдэд өсөн нэмэгдэж байгаа. Өнгөрсөн 3 жилийн хугацаанд Монгол Польшийн худалдааны эргэлт 2 дахин нэмэгдэж, 100 сая ам.долларт хүрсэн түүхэн үзүүлэлтийг үзүүлсэн. Хөрөнгө оруулалтын хувьд болбол Польш улс манай улсад 10 сая орчим ам.долларын хөрөнгө оруулалт оруулсан байдаг. Голлон хүнсний үйлдвэрлэл, мах, сүү сүүн бүтээгдэхүүн мөн барилгын материалын үйлдвэрлэлд хөрөнгө оруулсан байдаг. Өнгөрсөн онд Польшийн Ерөнхийлөгч Дудагийн Монгол Улсад хийсэн төрийн айлчлалын үеэр зохион байгуулсан Бизнес форумын форумгаас гарахад 2 орны хооронд худалдаа, хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэх сонирхол бизнес эрхлэгчдийн дунд байгаа нь харагдсан. Иймд хэрэв Элчин сайдаар томилогдон ажиллах юм бол 2 орны худалдаа, эдийн засгийн хамтын ажиллагаа мөн Польшоос Монгол Улсад орж ирэх хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэх чиглэлд анхааран ажиллах болно.

Польш улсад суугаа Монгол иргэдийн хувьд одоогоор 1000 орчим иргэн Польшид амьдарч байна. Ихэнх нь уламжлалт анагаах ухааны эмч нар байдаг. Польшид бас Польш дахь Монголчуудын холбоо, Польшид суралцаж байгаа оюутнуудын холбоо, Польш дахь анагаах ухааны эмч нарын холбоод үйл ажиллагаа явуулж байгаа. Эдгээр холбоод нь Польшид суугаа ЭСЯ-тай нягт холбоотой ажилладаг, олон арга хэмжээг хамтран зохион байгуулдаг. Цаашид бас үүнийг дэмжин ажиллах болно. Мөн тэнд ажиллаж, амьдарч байгаа Монгол иргэдийнхээ эрх ашгийг хамгаалахын төлөө ажиллана.

Б.Энх-Амгалан: Баярлалаа. Монгол Улсаас Шведийн Хаант Улсад

суух Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин сайдад нэр дэвшигч Цэрэндоржийн Мөнх-Өлзий хариулъя. 4 номерын микрофон уу.

Ц.Мөнх-Өлзий: Ганбат гишүүний асуултад хариулъя. Монгол Улсад Шведийн хаант улсаас оруулсан нийт хөрөнгө оруулалтын хэмжээ бол яг өнөөдрийн байдлаар 660 орчим мянган долларын ийм хөрөнгө оруулалт, 2 орны худалдааны эргэлт бол өнгөрсөн оны байдлаар 1 сая 360 орчим мянган доллар гэсэн ийм худалдаа, хөрөнгө оруулалтын эдийн засгийн хамтын ажиллагаатай байгаа. Элчин сайдаар томилогдох бол 2 орны худалдаа, хөрөнгө оруулалтыг өргөжүүлэх, мөн хөрөнгө оруулалт, худалдааны салбарыг аль болохоор солонгоруулах, Монгол Улсаас Шведийн хаант улсад гаргаж болох экспортын бүтээгдэхүүний нэр төрлийг нэмэгдүүлэх чиглэлээр онцгой анхаарч ажиллах ёстой юм болов уу гэсэн ийм ойлголттой байгаа.

Шведийн хаант улсад одоогийн байдлаар л 12 мянга орчим Монгол иргэн ажиллаж, амьдарч байгаа. Үүний 10500 орчим нь бол хууль ёсоор бичиг баримттай албан ёсны ажил хөдөлмөр эрхлээд ажиллаж байна. 2 мянга орчим иргэд бол одоогийн байдлаар хууль бусаар буюу бичиг баримтгүй гэсэн ийм статустай амьдарч байгаа. Иргэдээс яг энэ ажиллаж, амьдарч байгаа иргэдээс тавьж байгаа гол асуудал бол нэг нийгмийн хамгааллын хэлэлцээрийг байгуулах асуудлыг бол байнга тавьдаг юм байна лээ. Манай улсын зүгээс бол Шведийн талд бол нийгмийн хамгааллын хэлэлцээр байгуулъя гэдэг саналаа бол өгчихсөн, хөөцөлдөж ажиллаж байгаа. Элчин сайдаар хэрвээ томилогдох бол юуны түрүүнд энэ 2 орны хооронд нийгмийн хамгааллын хэлэлцээрийг байгуулах талаар бол идэвхийлэн ажиллах ёстой юм байна гэж ийм ойлгож байгаа.

Иргэдийн эрх ашгийг хамгаалах талаар бол сүүлийн үед бол манай ГХЯ

яамны удирдлагын зүгээс чиглэл заавар өгөөд бүх дипломат төлөөлөгчийн газар бол иргэдийн эрх ашгийг хамгаалах асуудалд онцгойлон анхаарч, нэлээн ахиц дэвшил гарч байгаа. Элчин сайдаар томилогдох тохиолдолд бол юуны өмнө иргэдийнхээ хууль ёсны эрх ашгийг хамгаалах, иргэдийн санаачилгаар байгуулагдсан ТББ болон холбоодын үйл ажиллагааг дэмжих, тус улсад үйл ажиллагаа явуулж байгаа сургууль, цэцэрлэгийн үйл ажиллагааг дэмжих болон төрийн үйлчилгээг иргэдэд түргэн шуурхай, чирэгдэлгүй хүргэх тал дээр онцгойлон анхаарна гэж бодож байна. Баярлалаа.

Б.Энх-Амгалан: Баярлалаа. Монгол Улсаас НҮБ-ын дэргэд суух Байнгын төлөөлөгчөөр нэр дэвшигч Нямдоржийн Анхбаяр Ганбат гишүүний асуултад хариулъя. 4 номерын микрофон.

Н.Анхбаяр: Ганбат гишүүний асуултад хариулъя. Та бүхний энэ өдрийн амгаланг айлтгая. АНУ-д 30 орчим, 30 гаруй мянган Монгол Улсын иргэн ажиллаж, амьдарч, суралцаж байна. Үүнээс 200 орчим, 200 гаруй иргэн Ньюйоркт ер нь тогтмол оршиж амьдарч суудаг. Эдгээр иргэдэд Байнгын төлөөлөгчийн газар дээр нэг ажилтан консулын үйлчилгээ үзүүлээд ингээд явж байгаа. 12-оос 14 онд Сан Франциско хотод Ерөнхий консулаар ажиллаж байсан туршилага бас Консулын газрын дэд захирал гэх мэтчилэн төвд ажиллаж байсан туршилагадаа тулгуурлаад энэ консулын үйлчилгээг зөвхөн Ньюйорк гэлгүй АНУ-д байгаа иргэдэд үзүүлэх үйлчилгээг сайжруулах, цахимжуулах, түргэн шуурхай болгох тал дээр үргэлжлүүлэн ажиллахаа илэрхийлж байна.

Худалдаа, хөрөнгө оруулалтын тухайд НҮБ, түүний төрөлжсөн байгууллага мөн НҮБ-ын хүрээнд батлагдсан гэрээ конвенцуудын хүрээнд энд суугаа суурин төлөөлөгчийн газартай нь хамтарч, 1 дүгээрт эрх зүйн хувьд Монгол Улсын худалдаа, хөрөнгө

оруулалтын эрх зүйн орчныг хэрхэн сайжруулах вэ, 2 дугаарт банк санхүүгийн чиглэлийн байгууллагатай доноруудтай харилцаж хэрхэн хөрөнгө оруулалт, эдийн засгийн худалдаа, эдийн засгийн түвшнийг дээшлүүлэх вэ гэдэг чиглэл дээр бас чармайн ажиллах болно.

Дахиад нэг зүйл онцолж хэлэхэд Монгол Улсад буюу Улаанбаатарт төвтэй Далайд гарцгүй хөгжиж орнуудын судалгааны төв гэж байдаг. Энэ судалгааны төв байгуулагдаад, хэлэлцээр нь хүчин төгөлдөр болоод тодорхой хугацаа өнгөрч байна. Энэ төвийн үйл ажиллагааг далайд гарцгүй орны хувьд, худалдаа хөрөнгө оруулалтын хувьд яаж үр ашигтайгаар ашиглах вэ, судалгааг хэрхэн сайжруулах тал дээр бас НҮБ-ын удирдлагуудтай, асуудал хариуцсан удирдлагуудтай нь Улаанбаатарт болон Ньюйоркт уулзалтууд хийж эхэлсэн байгаа. Энэ чиглэлээрээ үргэлжлүүлэн ажиллахаа илэрхийлж байна. Та бүхэнд баярлалаа.

Б.Энх-Амгалан: Баярлалаа. Тодруулах уу? Ганбат гишүүн 1 минут тодруулъя.

Д.Ганбат: Энэ Солонгосын хувьд визийн нөхцөл байдал нь бол шал өөр болж эхэлж байгаа. Ажиллангуутаа ажиллаж болдог тийм визийг ч гэсэн гаргаж байгаа гэсэн ийм мэдээлэл байгаа. Энэ дээр анхаарч ажиллах хэрэгтэй. Нөгөө талаар бол энэ Төв Азийн орнууд болох Узбекистан, Казахстан энэ ОХУ-ын иргэд чинь Солонгост бүгд визгүй байгаа шүү дээ. Манайх тэр түүхээ ч бодсон, энэ ардчилсан улс орны хувьд ч бодсон тэд нараас дор байна гэж юу байх вэ дээ. Энэ дээр анхаарч ажиллах ёстой шүү тэрийг хэлчихье.

Нөгөө талаар өмнө бид нар чинь Солонгос руу Элчин сайдыг бас оруулж ирээд л ярилцаад л ингээд л явуулж байсан. Тэгээд миний ойлгож байгаагаар бол тэр итгэмжлэх жуух бичгээ барьсан юм уу, бариагүй юм уу, тэр өмнө явсан

хүмүүсийн хугацаа энэ тэр нь юу болсон бэ? Тэд нар нь дуусаад явж байгаа юм уу эсвэл ямар нэгэн шалтаг шалтгаан байна уу?

Б.Энх-Амгалан: Асуултад Гадаад харилцааны сайд Батцэцэг хариулъя, 3 номерын микрофоныг өгье.

Б.Батцэцэг: Визний тухайд бид нар үргэлжлүүлээд ажиллана. Одоо ч гэсэн их анхаарч байгаа. Тэгээд Сүхболд сайд маань очоод бас энэ асуудлаараа үргэлжлүүлээд ажиллана. Өмнөх нэр дэвшигч Энхбат гээд Элчин сайдад бас нэр дэвшүүлж байсан хүн бол айлын талаас хариу ирээгүй, явцын дунд өөрөө хувийн шалтгаанаар татгалзсан байгаа. Тийм учраас Сүхболд захирлыг нэр дэвшүүлж байгаа.

Б.Энх-Амгалан: Гишүүд асуулт асууж, хариулт авч дууслаа. Монгол Улсын Ерөнхийлөгчийн санал болон нэр дэвшигчидтэй холбогдуулан үг хэлэх гишүүд нэрсээ өгнө үү. Нямаагийн Энхболд гишүүнийг нэмээрэй, Нямаагийн Энхболд гишүүнээр тасаллаа. Сэргэлэн гишүүн үгээ хэлье.

Ц.Сэргэлэн: Баярлалаа би нэр дэвшиж байгаа нэр дэвшигч нарыг бүгдийг нь дэмжиж байгаа. Ялангуяа сүүлийн үед Батцэцэг сайд ер нь энэ Гадаад харилцааны сайдаар томилогдсоноос хойш манай гадаад харилцааны асуудал ер нь болбол сайн гэсэн үнэлгээтэй л бүх шатад үнэлэгдээд яваад байгаа юм. Энэ оруулж ирж байгаа Элчин сайдуудыг томилох асуудал ч гэсэн нэлээн бас хууль, эрх зүйн хүрээнд таарсан тохирсон. Тэр дундаа бас нэр дэвшигч нар орж ирж байгаа энэ хүмүүсийн боловсрол, мэдлэг, ажлын дадлага туршлага гэх мэтчилэн олон зүйлийг харахад болбол яалт ч үгүй л томилогдох ёстой л хүмүүс шаардлага хангаад орж ирж байна. Амьдрал дээр зарим хүмүүс шаардлага хангахгүйгээрээ буцдаг, маргаан үүсдэг ийм асуудлууд байсан болбол энэ удаад бол маш сайн ийм томилгооны саналыг оруулж ирж

байна гэж би 1 дүгээрт сайшаах гэсэн юм.

2 дугаарт нэр дэвшиж байгаа хүмүүс дотор Сүхбат байж л байна, энэ Анхбаяр байна. Би урьд нь хамт Үндэсний аюулгүй байдлын зөвлөлөөс өгсөн үүрэг чиглэлийг хэрэгжүүлэхээр тусгай төсөл дээр бас хамт ажиллаж байсан юм. Энэ утгаар нь сайн мэднэ. Ялангуяа Сүхболдыг, мөн Анхбаярыг ажилд яаж хандагийг нь. Тэгээд томилогдож байгаа энэ албан тушаалууд нь тэр өмнө нь гүйцэтгэж байсан чухал үүргүүдтэй холбогдож байгаад би бас их олзуурхаад байгаа юм. Энийг та бүхэн би илээр хамаагүй яриад байх боломжгүй учраас ерөнхийд нь хэлчихье. Энэ юу вэ гэхээр Монгол Улсын үндэсний язгуур ашиг сонирхлыг хангах гадаад таатай нөхцөлийг хангах таатай тийм боломжийг бий болгох л чиглэгдсэн ийм л томилгоо шүү дээ. Та бүхний томилгоо бол үндсэн чиглэлд. Зүгээр нэг энгийн дипломат ажилтны томилгоо бол ингэж орж ирдэггүй. Сайд нь томилоод, томилоод л явуулчихдаг. Та бүхэн бол дипломат төлөөлөгчийн газрын тэргүүн. Энэ утгаараа би саяын юмыг хэлж байгаа юм. Энэ юуг хэлж байгаа юм бэ гэхээр Монгол Улсын үндэсний язгуур ашгийн сонирхлыг хангах гадаад таатай нөхцөлийг бий болгох үндсэн үүргийг хүлээж явдаг ийм онцлогтой учраас ЗГ, Ерөнхийлөгч буюу Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн тэргүүн, тэгээд Их хурал гэсэн энэ олон субъектүүдээр энэ томилгоо яригдаж орж ирдэг. Энийгээ та бүхэн бүгдээрээ мэдэж байгаа гэж би ойлгож байна.

Тэгэхээр энэ чухал хариуцлагатай албанд ажиллахдаа миний саяын хэлсэн юм та бүхний зүрхэнд энэ Монголын ард түмний үндэсний язгуур ашиг сонирхол мөнхөд хадаатай, энэний төлөө та бүхний зүрх цохилох ёстой. Ийм ч учраас та бүхэн тангараг өргөдөг гэж би ойлгодог. Энэ бол төрийн тусгай алба. Тэгээд амжилт хүсье. Ялангуяа би сая нэр заасан 2 хүндээ бол бүүр та 2-ын хийж гүйцэтгэж явсан тэр ажил үйлс

чинь энэ томилогдож байгаа албан тушаалд чинь ажиллахад ихээхэн чухал туршилага болно гэдгийг бас давхар хэлье. Баяр хүргэе дээ, амжилт хүсье.

Б.Энх-Амгалан: Цэдэвийн Сэргэлэн гишүүн үг хэллээ. Дамдины Цогтбаатар гишүүн үг хэлье.

Д.Цогтбаатар: Надтай олон жил ажиллаж байсан залуус маань орж ирж байна. Тэгэхээр 1 хэдэн зүйлийг хэлчихмээр байна. Түүрхэн юм асуух гэснээ больсон. Энэ гадаад бодлогыг эдийн засагжуулах хөтөлбөр гэж анх бид нар батлуулаад, ЗГ-аар батлуулаад явж байхдаа энэ дипломатуудын эдийн засаг, худалдаа, хөрөнгө оруулалтын чиглэлээр сэтгэх сэтгэлгээ тэр бодлын чиглэлийг бид нар үндэс сууриар нь бас өөрчилж, Монгол хүний амьдрал амьжиргаатай дипломат хүний ажил шууд уялдаатай байх тал дээр анхаарч ажиллаж байсан юм. Тэгээд энэ дээрээ их онцгой анхаарч ажиллах хэрэгтэй байгаад байна. Зүгээр тоо баримт ярихаар их гоё сонсогдоод байж магадгүй. Тэгэхдээ өнөөдөр зүгээр л логигоор та нар өөрсдөө бодоод үзээрэй.

Гадаадын хөрөнгө оруулалтын хууль өнөөдөр хэлэлцээд явж байна шүү дээ. Тэгээд энийг хэлэлцэж байгаагийн гол шалтгаан нь юу вэ гэхээр гадаадын хөрөнгө оруулалт навс уначихсан л байж байгаа байхгүй юу даа. Тэгэхээр одоо энийг буцаагаад сэргээх тал дээр онцгой анхаарч ажиллах ёстой. Энэ дээрээ тэгэхээр илүү тоо баримттай, илүү судалгаатай ажиллах хэрэгтэй болно. Жишээлбэл ингээд л ярихаар гоё сонсогдоно шүү дээ. Солонгостой чөлөөт худалдааны хэлэлцээр хийх хийгээд эхэлчихсэн явж байгаа байхгүй юу. Яагаад өмнө нь байгуулдаггүй байсан юм бэ? Эсхүл тэд нар нь тархигүй тэнэг байсан юм уу. Яагаад өнөөдөр хэлэлцээ эхэлчихсэн явж байгаа юм. Худалдааны үр ашгийнхаа судалгааг хийсэн үү, судалгааны чинь үр дүн ашиг нь, юу тэнцэл нь ашигтай гарч байна уу, сөрөг гарч байна уу энэ бүх судалгаануудаа бас

хийж ийм байдлаар хандах ёстой. Тэгэхээр хариуцаж ажиллаж байгаа хүмүүс энэ дээрээ илүү анхаарч ажиллаарай гэж хэлмээр байна.

Нөгөө талаас гадаад бодлого бол би Элчин сайд нартаа хандаад олон жил ажиллаж байсан хүмүүс болохоор гадаад бодлогын энэ уламжлал чанарыг бас мэдэх хүмүүс гэж ойлгоод би сануулаад хэлмээр байна. Энэ PR шоуны салбар биш шүү. Гадна талдаа юмыг хэчнээн гоё яриад байгаа ч дотоод бодит өгөгдөхүүн ярьж байгаа хэмжээндээ биш байгаа тохиолдолд үнэнд гүйцэгдэнэ. Энэ эрсдэл эргээд Монгол хүний зүгээр энгийн Монгол хүний амьжиргаанд мэдрэгдэнэ. Энийгээ бид нар аягүй сайн анхаарч ажиллаж байх ёстой. Тэгэхээр энэ дээрээ нэг хэдэн зүйлийг хэлмээр байгаа юм. Одоо ингээд иргэдтэйгээ харьцахдаа дипломат салбар гэдэг бол маш рационал салбар юм шиг боловч энэ иргэдтэйгээ харьцаж байгаа хүмүүс бол хүн чанартай, эрүүл сэтгэхүйтэй, ёс суртахуунтай харьцдаг байх ёстой. Түүнээс камерын өмнө нэг юм ярьчихаад, цаанаа иргэдтэйгээ зүй ёсоор харьцахгүй байгаад байвал иргэдийн чинь гомдол буцаад л ирээд байна гэсэн үг. Тэгэхээр энэ дээрээ тэр гадаад түншүүдтэйгээ харьцахдаа ч гэсэн тэр ёс суртахуун бас нэг хэлсэн ярьсандаа байх энэ зарчмаа бол барьж байх ёстой.

Тэгээд энэ бас манай Сүхболд, Гунаажавын юу Байгалмаа, энэ Анхбаяр, нөгөөдөх нь хэн байна вэ? Тийм Мөнх-Өлзий бүгдээрээ надтай ажиллаж байсан хүмүүс. Нэг юмыг та нар маань бас ахиад юу бодож ажиллаарай. Тэр эдийн засагжуулах хөтөлбөр дээрээ ажиллана биз. Сүхболд энэ нөгөө дипломат юу Монгол Улсын бүх НҮБ-ын дипломат гишүүн юу гишүүн орнуудтай дипломат харилцаатай болгоорой гээд энэ өгөөд захиж байсан тэр үеийн юу чинь бол өнөөдөр хэрэгжээд явж байгаад би их баяртай байгаа. Монгол Улс НҮБ-ын бүх оронтой дипломат харилцаатай болсон байгаа. Би ажлаар очиж байхад

3-хан орон үлдсэн байсан юм. Тэгээд энэ 3 орныг гүйцээгээд ажиллах ёстой гээд Сүхболд бол 1-тэй нь амжиж байгуулаад ирж байсан шиг санаж байна. Тэгээд ажил нөгөө гадаад бодлого уламжлалт чанартай учраас гүйцээд бүх салбарт юу бүх орнуудтайгаа гүйцээгээд байгуулсан байгаа нь их чухал байгаа гэж үзэж байгаа гэх мэтээр ингээд ер нь бол ажлынхаа юу амжилт дээр суурилоод цаашаа амжилттай ахиулаад ажиллах ёстой шүү. Тэгээд залуучуудад амжилт хүсье.

Б.Энх-Амгалан: Баагаагийн Баттөмөр гишүүн үг хэлье.

Б.Баттөмөр: Оруулж ирж байгаа томилгоо болбол сонголт бол маш сайн хийсэн байна. Энэ зүйтэй, мэргэжлийн хүмүүс ажиллах юм байна. Өнгөрсөн энэ 4 дэх жилдээ ороод явж байна. Би бас Гадаад бодлого, аюулгүй байдлын байнгын хорооны даргаар ажиллаж байсны хувьд бол Гадаад яамны ажлыг бас нэлээн сайн мэднэ л дээ. Тэгээд манай Батцэцэг сайдын хувьд болбол сайн ажиллаж байгаа. Энийг бас эмэгтэй хүний хувьд би бас өнөөдөр бас нэг шууд хэлчихье гэж бодож байна. Төрийн нарийн бичгийн дарга Анхбаяр маш сайн ажиллаж байгаа. Яамны аппарат болбол маш сайн ажиллаж байгаа. Өнгөрсөн хугацаанд энэ салбаруудаараа авч үзэх юм болбол хамгийн сайн ажилласан салбар бол манай гадаад харилцааны салбар. Дарга нарын хувьд бол сонголтуудыг маш сайн хийдэг, улс төржөөгүй. Ялангуяа энэ гадаад харилцааны салбарт ажиллаж байсан хүмүүсээ их зөв сонгож газар, хэлтсийн дарга нараа их сайн байршуулж, их сайн ажилласан. Ганц нэг томилгооны асуудал гадна бий. Тэр нь болбол энэ сайд, төрийн нарийн бичгийн даргаас хамаарахгүйгээр тийм томилгооны юмнууд байсан. Энэ томилгоонууд болбол үнэхээр бас нүдээ олчихсон байна гэж ингэж үзэж байна.

Энэ сая миний хэлэх гэж байсан үгийг энэ Цогтбаатар гишүүн хэлчихлээ.

Гадаад харилцааг эдийн засагжуулах гээд. Улсын Их Хурал дээр Хөрөнгө оруулалтын хуулийг өнөөдөр хэлэлцэж байгаа юм. Хөрөнгө оруулалтын хууль дотор орж байгаа юм гэхээр гадаад харилцааг эдийн засагжуулах, ЭСЯ, дипломат төлөөлөгчийн газарт болбол энэ хөрөнгө оруулалтыг Монголд татах чиглэлээр их идэвхтэй ажиллах, тэд нарыг ажлыг тэр чиглэлээр нь бас үнэлдэг шалгуур бий болгох гээд ийм асуултууд энэ дотор явж байгаа юм. Тийм учраас энийг анхаарч ажиллах шаардлагатай. Манай худалдааны бодлого ер нь нэг эзэнгүй яваад байдаг. Энэ дотор яг хаана хариуцаж байна вэ гэхээр Гадаад яам хариуцдаг гэдэг юм тэгээд. Манайд Худалдааны хууль байдаггүй. Бид худалдаа хийж чадахгүй байгаа шүү дээ. Зөвхөн нүүрс гээд л тэгтэл Хятадад ОХУ-аас нийлүүлж байгаа нүүрснээс 18 хувиар хямд, бусад зах зээл том орнуудаас Австрали энэ тэрийн оруулж байгаа нүүрснээс 50 хувиар хямд явдаг. Тэгээд энэ худалдааны чиглэлийн юманд болбол их анхаарч манай ГХЯ анхаарах ийм шаардлагатай гэж үзэж байгаа.

Энэ манай эдийн засагт бас нэг ч чухал нөлөө үзүүлж байгаа салбар аялал жуулчлал. Энэ чинь бараг 8, 9 зуугаад мянган хүн ирчихсэн 1 тэрбум долларын долларыг эдийн засагт оруулсан гэсэн ийм тооцоо байгаа шүү дээ. Тийм учраас манай Элчин сайдуудын хувьд болбол энэ аялал жуулчлалын салбарт их анхаарах ёстой. Бид нар ч гэсэн дотооддоо энэ аялал жуулчлалыг болбол бас тийм чанартай хийх ёстой. Гаднын хүмүүсийг харахаар мөнгө гэж нүдээр харж биш, сайн үйлчилгээг үзүүлэх ёстой. Сая Солонгосын телевизээр манай энэ аялал жуулчлалын тэр үнэтэй холбоотой маш их том шүүмжлэлүүд явж байна лээ шүү дээ. Тийм учраас дотооддоо бид нар их сайн анхаарах ёстой. Байгаль орчны яамтайгаа хамтарч энэ чиглэлд анхаарах ийм шаардлагатай гэж ингэж үзэж байна.

Шинээр томилогдсон сайд нар болбол энэ түрүүн ажиллаж байсан улсуудынхаа ажлыг сайн үргэлжлүүлэх ёстой. Ялангуяа энэ тэр Шведэд байж байгаа Мөнх-Өлзий Жанабазар сайд бол их сайн ажиллаж байгаа шүү. Маш их судалгаануудыг хийсэн байгаа. Ер нь болбол Монгол Улс чинь энэ нөгөө зүүний үзэл баримтлалтай энэ эрх барьж байгаа нам маань ийм байж байгаа. Ер нь цаашидаа болбол юу вэ гэхээр нөгөө тэр чиглэл рүү социал демократ тэр чиглэл рүү нь илүү явна гэж ингэж тооцож байгаа шүү дээ. Тийм учраас тэдний туршилага бидэнд болбол асар их туршилагатай байгаа.

Ер нь бол Элчин сайдуудад болбол бас нэг чухал юм бол тэр тухайн улсынхаа хэлээр ярьдаг л их чухал байгаа юм. Энэ Хятадын Элчин сайд чинь Хятадаар ярьдаг байлаа, Японы элчин сайд Японоор ярьдаг байлаа, юу Монголоор ярьдаг байлаа. Хятадын Элчин сайд Монголоор ярьдаг байлаа. Тэгэхээр ингээд Солонгост сууж байгаа Элчин сайд, Польшид суугаа, Шведэд сууж байгаа улсууд тэр улсуудынхаа хэлийг бас үзэх харах, тэнд ажиллаж байгаа мэргэжлийн сайн хэлтэй хүмүүстэйгээ, Солонгост бол сайн хэлтэй хүмүүс байгаа шүү дээ. Тэр Тэнүүн энэ тэр гээд Консулын газрын дарга их мундаг залуу байгаа. Польш гээд тэгтэл түрүүн дээхэн үед Оросоор ярьдаг байсан, одоо ч бараг Оросоор ярихаа больсон биз. Ер нь Зүүн Европт байгаа Монголын ардчиллыг дэмждэг гол улсуудын нэг шүү дээ тийм ээ. Тэгээд энэ тэр дээрээ сайн ажиллах ийм шаардлагатай гэж ингэж үзэж байна. Тэгээд яах вэ дээ сая сайдын үгэнд ярьчихлаа, тэр гадаадад ажиллаж байгаа улсуудынхаа ёс зүйтэй холбоотой, дунд тушаалын албан тушаалтнууд дээр бас янз янзын асуудлууд гардаг. Тэгээд энэ дээрээ л анхаарч ажиллая даа. Тэгээд та бүгдэд ажлын амжилт хүсье бүгдэд нь. Сайн ажиллацгаагаарай. Монгол Улсын ерөнхий байдал бол жоохон төвөгтэй

байгаа. Улс орныхоо хөгжил.../минут дуусав/

Б.Энх-Амгалан: Нямаагийн Энхболд гишүүн үг хэлье.

Н.Энхболд: Элчин сайд нарыг томилох бас тийм амар ажил биш. Олон янзын шалгуур, олон хүчин зүйл, олон байгууллага, улс төрийн нөхцөл байдал элдэв янзаас шалтгаалаад мэргэжлийн дипломат нарыг ч томилдог тохиолдол бий, туршилагатай, мэдрэмжтэй, сэтгэлтэй яг мэргэжлийн дипломат биш ч гэсэн Монгол Улсаа төлөөлөөд ажиллаж чадах хүмүүсийг ч томилдог тохиолдлууд байдаг. Энэ удаа болбол дандаа Гадаад яамны мэргэжлийн дипломатч нар яг нас, ажлын туршилага бүх юм нь жигдэрсэн ийм хүмүүс нэр дэвшээд явж байна. Би бүгдийг нь дэмжиж байгаа. Зарим нь миний ажилд авч байсан хүмүүс байна, зарим нь энд тэнд томилж байсан хүмүүс байна. Зарим нь яг хамтраад ажиллаж байсан хүмүүс байна. Бүгдээрээ энэ Монгол Улсаа төлөөлөөд Элчин сайдаар ажиллаж чадах ийм боломжтой улсууд гэж харж байна. Бүгдийг нь дэмжинэ, амжилт хүсэж байна.

Тэгээд сая манай гишүүд бас анхаарах зүйлүүд дээр нэлээн ярьчихлаа. Би зүгээр нэг юмыг яг цаг үеийн байдалтай уялдуулаад, одоо хэзээ та нар очихыг би сайн хэлж мэдэхгүй байна. Бодвол эхний хагас жилдээ багтаад явах болов уу. Зарим нь ч наана, цаана явж магадгүй. Иргэдтэй харьцах юмнуудтай асуудалтай холбогдуулаад хэлэхэд энэ зун Улсын Их Хурлын сонгууль болно. Энийг суугаа, суугаа орондоо зохион байгуулах үүргүүдийг Элчин сайд нар хүлээж байгаа хуулиар. Эндээс яг энэ хүмүүс иргэдтэйгээ яаж харьцаж байна, төрийн бодлогод яаж харьцаж байна, иргэдийнхээ сонгох, сонгогдох эрхийг хангахад ямар байдлаар хандаж байна гээд тухай, тухай оронд ажиллаж, амьдарч, сурч байгаа Монголчуудыг дүгнэлт хийх хамгийн том нэг шалгуур энэ болно. Тэгэхээр энэ дээр та нар хэрэв

сонгуулиас өмнө томилогдоод очоод ажилдаа орвол тэнд байгаа хүмүүст үнэлэгдэх гол эхний том ажил чинь энэ болно шүү. Энэ дээр маш их сэтгэл гаргаж, аль болохоор олон хүнийг хамруулж ажиллах тал дээр онцгой анхаарч ажиллаарай гэж бүгдэд нь зөвлөе, анхааруулж байна.

Тэгээд ер нь бид нар чинь өөрснөө жижиг улс. Улс орноо одоогийн энэ хүнд нөхцөл байдалд бид нар яагаад дэлхийд болж байгаа энэ том тиктоник өөрчлөлтийн үед ийм байр суурь баримталж асуудалд хандаж, олон улсын байгууллагууд дээр саналаа өгч байна гэдгийг их зөв ойлгуулж явах болбол цаашидаа ч улам олон жилийн үр дагуулсан ийм чухал ажил болно. Энэ дээр төрийн бодлого, яамныхаа бодлого байр сууриа маш зөв талаас нь ойлгуулж явбал энэ их та нарын ойрын жилүүдийн их том ажлуудын нэг болно. Одоо зүгээр ганцхан жишээ гэхэд Орос Украины дайнтай холбоод Польшчууд ямархуу байр суурь баримталдаг билээ, Орост яаж ханддаг билээ. Манай тэднийтэй харьцаж байгаа харьцааг юу гэж дүгнэж байна, харж байна. Энэ дээр маш зөв ойлгуулах тал дээр болбол жишээ нь Байгалмаа сайд их нарийн ухаан гаргаж, зөв ажиллах хэрэгтэй гэж санагдаж байна.

Тэгээд бусад нь тухай тухайн газраа ч гэсэн энэ ажлыг анхаарч ажиллаарай гээд 2 зүйлийг, 1 дүгээрт тэр сонгууль тэр чинь өөрсдөө цаашидаа иргэдтэйгээ яаж харьцах, тэдэнд яаж хандаж байгааг харуулах нэг том үзүүлэлт болно шүү гэдгийг, 2-т одоогийн энэ нөхцөл байдалд улсынхаа байр суурийг ялангуяа бид нарыг чинь янз бүрээр л харж байгаа, янз бүрээр дүгнэж байгаа. Үүнийг их зөв ойлгуулах тал дээр нь анхаарч ажиллаарай гэдгийг хэлье. Дахиад тодруулаад энэ 2 зүйлээ ингээд. Бүгдийг нь дэмжиж байна. Дахиад хэлэхэд дахиад л ерөнхийдөө яг аль, аль, аль ч талаасаа нас, туршилага ажиллаж байсан байдлаасаа талаас нь харахад шаардлага хангасан ийм хүмүүс оруулж

ирж байна. Бид нар ч бас урьд нь жишээ нь Солонгост ямар хүнийг томилчхоод одоо болтол асуудал нь шийдэгдэхгүй, дараагийн хүн нь яригдаж байгаа үе дээр ингээд бодоод үзэхэд бас анхаармаар зүйлүүд байдаг. Тэгэхээр энийг би тэр эхлээд хэлэхдээ энэ томилолт бол төвөгтэй байдаг л даа гэдгийг хэлсэн нь бас энэ, энэ юмнуудаа цаашидаа Батсүх сайд тийм ээ.../минут дуусав/

Б.Энх-Амгалан: 2, 3 зүйлийг бас хэлье. Монгол Улсын Ерөнхийлөгчөөс санал болгож байгаа Дипломат төлөөлөгчдийн газрын тэргүүнд нэр дэвшиж байгаа Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин сайд болох гэж нэр дэвшиж байгаа бүх нэр дэвшигчдийг бол дэмжиж байгаа юм. Мэргэжлийн хүмүүс орж ирж, яамны үндсэн аппаратын мэргэжлийн дипломатууд орж ирж мөн энэ салбартаа олон жил үр бүтээлтэй ажилласан ажлын туршилагатай ийм хүмүүс орж ирж байгаад бол баяртай байна. Тэгээд ер нь Монгол Улсын гадаад харилцаа бол олон талтай болж хөгжиж, Монгол Улсын нэр хүнд дэлхийн тавцанд бас өсөж байгаад их баяртай байгааг бас энд хэлье.

Нэг хэд хэдэн зүйлийг та бүхэн маань нэг анхаараач гэж хүсэж байгаа юм. 1 дүгээрт энэ ирж байгаа Элчин сайдуудад ерөөсөө бид нар тайлан гэж өгдөггүй, явахад нь л нэг баахан ингээд л нөгөө цэрэгт юм уу, сургуульд хүүхдээ үдэж байгаа юм шиг л баахан сургаал айлддаг. Ингээрэй, тэгээрэй, ийм юм хийгээрэй, тийм юм хийгээрэй гээд явуулчихдаг. Тэгээд яваад ирэхэд нь чи юу хийгээд ирэв гэж асуудаггүй. Тийм учраас ирэхдээ бас тэр хүмүүс тайлангаа өгдөг баймаар байна. Ядаж Байнгын хороондоо, мэргэжлийнхээ Байнгын хороондоо. Тэгэхгүй бол тэр хүмүүс чинь одоо ингээд л сая хэлж байна шүү дээ. Хувийн шалтгаанаар татгалзчихлаа гээд л. Үгүй ээ ингэж болдог юм уу? Монгол Улсын нэрийн өмнөөс ингэж оччихоод, хувийн шалтгаанаар би татгалзлаа, би болилоо, би тэглээ. Ийм дураараа юм байж

болохгүй биз дээ. Тийм учраас энэ бүгд дээрээ ёстой онцгой анхаарч, тэгээд юу хийв, юу бүтээв гэдгийг нь тайлагнадаг ийм шалгууртай болмоор байна.

2 дугаарт ЭСЯ-ны шалгуур үзүүлэлт гэж нэг юм гаргамаар санагдаад байдаг юм. Зарим нь маш идэвхтэй сайн ажиллаад байдаг, зарим нь таг унтаа байгаад байдаг. Би зүгээр явж үзсэн хэдэн газруудаа сая харж байна л даа. Жишээлбэл Хятад гэхэд Бадрал Элчин сайд ямар их санаачилгатай ажиллаж байна. Хятадын ЭСЯ-ыг би сайн мэднэ. Тэгэхэд одоо бол тэрийг зассан янзалсан нэг улс орны нүүр царайг харуулсан, тэр соёлын төвөө янзалсан, гадаад харилцаандаа идэвхтэй болсон, ялангуяа Хятадад хөгжиж байгаа тэр цахим худалдааны платформ дээр Монгол Улсын бараа бүтээгдэхүүнийг гаргах тал дээр, тэр хиймэл оюун ухааныг ашиглах тал дээр, тэр цахим платформ дээр цахим худалдааны дэд бүтцийг байгуулах тал дээр маш санаачилгатай ажиллаж байгаа юм байна лээ. Би бол тэнд оччихоод яг энэ тал дээрээ болбол их сүрхий ажиллаж байгаа юм байна даа гэж ингэж харсан.

Вьетнамд энэ Сережев Элчин сайдын энэ үед чинь ингээд шууд нислэгтэй болчихлоо. Харилцан визгүй болчихлоо. Монголчууд ингээд эндээ биш Вьетнамд хуримладаг болж байна шүү дээ. Энэ бол бас сайн тал. Лаосын Элчин сайд энэ олон улсын парламентын хурал Лаост хийхтэй холбогдуулаад бэлтгэл ажлууд хийж байгаа юм байна. Лаосын Ерөнхийлөгч Монгол Улсад айлчлах гэж байгаа юм байна. Ерөнхийлөгчийн Тамгын газрын дарга нь айлчлах юм байна. Мөн энэ Лаосын Үндэсний Ассамблейн дэд дарга айлчлах юм байна. Ингээд өндөр түвшний харилцан айлчлалын давтамжийг 2 талдаа идэвхтэй сайн хийж, худалдааг сайжруулах тал дээр ажиллаж байгаа энэ хүмүүстээ бас нэг шалгуур тавимаар. Туркт байгаа Элчин сайд гэхэд энэ батлан хамгаалах салбар, эрүүл

мэндийн салбар, зам тээврийн салбар дээр маш их санаачилгатай ажиллаж байна лээ. Тэгээд ингэж санаачилгатай ажиллаж байгаа хүмүүстээ ямар шалгуур тавих вэ, зүгээр байгаа хүмүүстээ ямар шалгуур тавих вэ гэдэг юмаа нэг ийм шалгуур үзүүлэлт тавивал уг нь зүгээр санагдаж байгаа юм. Нэг адилхан. Чи ингэж ажилласан учраас дараа нь ингэнэ гэдэг нэг. Тэгэхгүй болбол адилтай адил, годилтой годил гэдэг шиг нөгөө хийхийг нь чи хий, хэлэхийг нь би хэлье гээд сууж байдаг бас байж таарахгүй учраас энийг бас нэг анхаараарай гэдэг юмыг би бас хэлж байгаа юм.

Элчин сайдын яаман дотор ажиллаж байгаа дипломат ажилчдадаа нэлээн сайн анхаарал тавимаар юм байна лээ. Сайдынхаа өмнөөс цор, цор гээд байдаг, үгэнд нь ордоггүй. Тэгээд юм ярихаар би тэгдэг ч үгүй, ингэдэг ч үгүй, өвчтэй зовлонтой, чөлөөтэй халаатай, тийм даргын хамаатан, тийм сайдын дүү гээд ингээд олон долоон юм яриад байдаг ийм юмнууд байдаг юм байна лээ шүү. Тийм учраас ЭСЯ, төлөөлөгчийн газрын тэргүүн өөрөө асуудлаа шийдээд, тохирохгүй бол явуулчихдаг баймаар байгаа юм. Тэгээд Элчин сайдынхаа үгэндээ ордоггүй нэг тийм том толгойтой юмнууд байж байдаг байж бас таарахгүй гэж энийг бас хэлж байгаа юм. Та бүхэн маань энийг анхааралдаа аваарай.

Тэнд байж байгаа иргэд байгаа юм. Иргэдтэй холбоотой асуудлаар гадаадын хүнтэй суучаад, тэгээд Монгол Улсаа муулаад, газар дор ортол муулаад, есөн шидээр нь хэлээд хашихчаад гуугчаад байдаг хүмүүс байдаг юм байна лээ. Тийм мундаг юм бол ирээд өөрсдөө хөгжүүлэхгүй юу, гадна талд суучаад эх орноо муулаад сууж байдаг ийм хүмүүс дээр бас ЭСЯ-ныхан нэлээн анхаарал тавьж ажиллах шаардлага хэрэгцээ байгаа юм байна лээ. Тэр фейсбүүкт ажиллаж байгаа байдал нь, тэр бичиж коментууд нь, хүний газар чинь хүн эх орноо л санадаг шүү дээ

уг нь. Төлөөлөгчийн газар луу, дипломат төлөөлөгчийн газар луугаа л уг нь очдог шүү дээ сэтгэл гаргаж, тэд нартайгаа тулж ажиллах, мэдээллээ зөв өгөх тал дээр нэлээн анхаарах ийм шаардлагууд байна лээ шүү гэдгийг та бүхэндээ хэлье. Тэгээд бүгдэд нь ажлын амжилт, сайн сайхан бүхнийг хүсье. Гишүүд үг хэлж дууслаа.

Санал хураалт явуулна. Монгол Улсын Ерөнхийлөгчөөс зөвшилцөхөөр ирүүлсэн Монгол Улсаас гадаад улсад суух зарим Элчин сайд нарыг томилох асуудлаар санал хураалт явуулъя. 1. Монгол Улсаас Бүгд Найрамдах Солонгос улсад суух Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин сайдаар Сүхээгийн Сүхболдыг томилох саналыг дэмжье гэсэн томъёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт. Санал хураалтад 13 гишүүн оролцож, 9 гишүүн дэмжиж, 69,2 хувийн саналаар уг санал дэмжигдлээ.

2. Монгол Улсаас Польш улсад суух Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин сайдаар Гунаажавын Байгалмааг томилох саналыг дэмжье гэсэн томъёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт. Санал хураалтад 13 гишүүн оролцож, 8 гишүүн дэмжиж, 61,5 хувийн саналаар санал дэмжигдлээ.

3. Монгол Улсаас Шведийн Хаант Улсад суух Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин сайдаар Цэрэндоржийн Мөнх-Өлзийг томилох саналыг дэмжье гэсэн томъёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт. 13 гишүүн санал өгснөөс 9 гишүүн дэмжиж, 69,2 хувиар уг санал дэмжигдлээ.

4. Монгол Улсаас Нэгдсэн Үндэстний Байгууллагын дэргэд суух Байнгын төлөөлөгчөөр Нямдоржийн Анхбаярыг томилох саналыг дэмжье гэсэн томъёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт. Санал хураалтад 13 гишүүн оролцож, 9 гишүүн дэмжиж, 69,2 хувийн саналаар уг санал дэмжигдлээ. Монгол Улсаас гадаад улсад

суух зарим Элчин сайд нарыг томилох асуудлаар санал хураалт явуулж дууслаа.

Монгол Улсаас гадаад улсад суугаа Элчин сайд нарыг эгүүлэн татах асуудлаар санал хураалт явуулъя. Монгол Улсаас Бүгд Найрамдах Польш суугаа Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин сайд Бархасын Дорж, Монгол Улсаас Шведийн Хаант Улсад суугаа Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин сайд Түвдэндоржийн Жанабазар, Монгол Улсаас Нэгдсэн Үндэстний Байгууллагын дэргэд суугаа Байнгын төлөөлөгч Воршиловын Энхболд нарыг эргүүлэн татах саналыг дэмжье гэсэн томьёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт. Санал хураалтын дүнг танилцуулъя. Санал хураалтад 13 гишүүн оролцсоноос 10 гишүүн дэмжиж, 76,9 хувийн саналаар уг санал дэмжигдлээ. Монгол Улсаас гадаад улсад суугаа Элчин сайд нарыг эгүүлэн татах асуудлаар санал хураалт явуулж дууслаа. Монгол Улсаас гадаад улсад суух Элчин сайд нарыг эгүүлэн татах, томилох асуудлыг зөвшилцөх тухай Монгол Улсын Ерөнхийлөгчийн саналыг хэлэлцэж дууслаа. Байнгын хорооны санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын нэгдсэн чуулганд миний бие танилцуулъя.

12.33 цаг

Тав. “Бүгд Найрамдах Узбекистан Улсын нийслэл Ташкент хотод Монгол Улсын элчин сайдын яам нээн ажиллуулах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл /Засгийн газар 2024.01.08-ны өдөр өргөн мэдүүлсэн, зөвшилцөх/

2 дахь асуудалдаа оръё. Ажлын хэсгийн гишүүдэд баярлалаа. Бүгд Найрамдах Казахстан Улсын нийслэл Ташкент хотод Монгол Улсын Элчин сайдын яам нээн ажиллуулах тухай Улсын Их Хурлын тогтоолын төслийг Узбекистан, Бүгд Найрамдах Узбекистан улсын нийслэл Ташкент хотод Монгол Улсын Элчин сайдын яам нээн ажиллуулах тухай Улсын Их Хурлын

тогтоолын төслийг хэлэлцэнэ. ЗГ 2024 оны 1 сарын 9-ний өдөр өргөн мэдүүлсэн. 2023 оны 1 сарын 10-ны өдрийн Байнгын хорооны хуралдаанаар хэлэлцэх зөвшилцөх асуудлыг Даргын зөвлөлөөр шийдвэрлэж, өнөөдөр энэ асуудал орж ирж байна.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 81.1-д хилийн чанадад ажиллах дипломат төлөөлөгчийн газрыг шинээр нээн ажиллуулах, түвшин, байрилыг тогтоох тухай тогтоолын төслийг Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн бол Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хороо хуралдаанаараа хэлэлцэн санал, дүгнэлт гаргаж, нэгдсэн хуралдаан ил санал хураалт явуулж, хуралдаанд оролцсон гишүүдийн олонхын саналаар шийдвэр гаргах бөгөөд энэ асуудлаар Улсын Их Хурал тогтоол батална гэж заасан.

Хуралдаанд хүрэлцэн ирсэн Ажлын хэсгийн гишүүдийг танилцуулъя. Батмөнхийн Батцэцэг Монгол улсын ЗГ-ын гишүүн, Гадаад харилцааны сайд, Нямдоржийн Анхбаяр ГХЯ-ны ТНБД, Дашпүрэвийн Амарсайхан мөн яамны Төрийн захиргаа, удирдлагын газрын захирал, Ганбаатарын Хулан мөн яамны Ази, номхон далайн орнуудын газрын захирал, Чүлтэмийн Ганбат ГХЯ-ны Төрийн захиргаа, удирдлагын газрын Санхүү, эдийн засгийн хэлтсийн дарга. Хэн байна вэ, нэмээд? Консул Болд байна уу тийм ээ, Болд консул нэмж ирсэн байна. Бүгд Найрамдах Узбекистан улсын нийслэл Ташкент хотод Монгол Улсын Элчин сайдын яам нээн ажиллуулах тухай Монгол Улсын Их Хурлын тогтоолын төслийн талаарх танилцуулгыг Монгол Улсын ЗГ-ын гишүүн, Гадаад харилцааны сайд Батмөнхийн Батцэцэг танилцуулна. Батцэцэг сайдын микрофоныг өгье, 2, 3 номерын микрофон.

Б.Батцэцэг: Эрхэм хүндэт Улсын Их Хурлын Байнгын хорооны дарга, эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Их Хурлын 2020 оны 24 дүгээр тогтоолын хавсралтаар баталсан Монгол Улсын ЗГ-ын 2020-оос 2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 4.5.5-д гуравдагч хөршийн бодлогын хүрээнд түншлэлийн харилцааг өргөжүүлэн, эдийн засгийн хамтын ажиллагааг бэхжүүлж бусад улстай харилцан ашигтай ашигтай хамтын ажиллагааг хөгжүүлэх чиглэлээр идэвхтэй ажиллана. 4.5.8-д улс төр, эдийн засгийн харилцааны түвшин, ач холбогдол зэргийг харгалзан дипломат төлөөлөгчийн газруудын байршил, бүтэц, орон тоог оновчтой болгоно гэж заасны дагуу Төв Азийн бүс нутагтаа хөдөө, аж ахуй, хөнгөн үйлдвэрийн хөгжлөөр тэргүүлдэг 35 сая хүн амтай, бүс нутагтаа томоохонд тооцогддог зах зах зээлтэй Бүгд Найрамдах Узбекистан улсын нийслэл Ташкент хотод Монгол Улсын ЭСЯ нээн ажиллуулах ЗГ-ын саналыг Улсын Их Хурлын Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хорооны 2023 оны 10 дугаар сарын 10-ны өдрийн хуралдаанаар хэлэлцэн зөвшилцөн дэмжсэн шийдвэр гарсан.

Байнгын хорооны дээрх шийдвэрийг үндэслэн Ташкент хотод Монгол Улсын ЭСЯ нээн ажиллуулах саналаа айлын талд дипломат шугамаар тавьж, зөвшөөрсөн хариу авсан тул холбогдох хууль тогтоомжийн дагуу Бүгд Найрамдах Узбекистан Улсын нийслэл Ташкент хотод Монгол Улсын ЭСЯ нээн ажиллуулах тухай Монгол Улсын Их Хурлын тогтоолын төсөл боловсруулсныг танилцуулж байна. Узбекистан нь Монгол Улсын хүнсний аюулгүй байдлыг хангах зорилгод нийцсэн эрүүл хүнсний бүтээгдэхүүний хангамжийг нэмэгдүүлэх, төрөлжүүлэх чиглэлээр хамтран ажиллах, манай үндэсний үйлдвэрлэгчдийн бүтээгдэхүүнийг тухайн бүс нутагт таниулах, эдийн засгийн харилцааг өргөжүүлэн худалдааны эргэлтийг нэмэгдүүлэх, Монгол Улсаас мах махан бүтээгдэхүүн, арьс шир, ноос ноолуурын, ноос ноолуурыг тухайн бүс нутгийн зах

зээлд нийлүүлэхэд чухал хувь нэмэр оруулах боломжтой улс гэж үзэж байна.

ЭСЯ-ыг 3 орон тоотой ажиллуулахаар төлөвлөсөн бөгөөд холбогдох зардлыг 2024 оны төсвийн төсөлд тусгаад байна. Иймд Бүгд Найрамдах Узбекистан улсын нийслэл Ташкент хотод Монгол Улсын ЭСЯ нээн ажиллуулахыг, ажиллуулах Улсын Их Хурлын шийдвэрийн төслийг хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг хүсье. Анхаарал тавьсанд баярлалаа.

Б.Энх-Амгалан: Батцэцэг сайдад баярлалаа. Бүгд Найрамдах Узбекистан улсын нийслэл Ташкент хотод Монгол Улсын ЭСЯ нээн ажиллуулах тухай асуудлыг 2023 оны 10 сарын 10-ны өдөр Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хороо хэлэлцэж дэмжсэн. Одоо ингээд орж ирж байна. Энэ тогтоолын төсөлтэй холбогдуулаад асуулт асуух гишүүд байвал нэрсээ өгнө үү. Ганбат гишүүнээр тасаллаа. Ганбат гишүүн асуултаа асууя.

Д.Ганбат: Ер нь бол Узбекистанд ЭСЯ маань нээх нь дэмжиж байна. Энэ бол зөв зүйтэй асуудал. Гадаад худалдаа, харилцан хоорондын харьцаа энэ тэр бол өргөжиж байгаа. Төв Азийн ер нь нэлээн том орны нэг, 35 сая хүнтэй. Энэ дээр тэр гайгүй үед нь энэ ЭСЯ-ны тэр газар нутаг байр энэ чинь Монгол Улсын л нутаг дэвсгэр болчихдог шүү дээ тийм ээ? Тэгж явдаг. Түрээсэлж суух гээд байна уу эсвэл худалдаж авах гээд байна уу? Би бол Узбекистан улс тусгаар тогтноод нэг их удаагүй байгаа. Цаашидаа энэ улс орон бол нэлээн хөгжиж байгаа улсуудын нэг. Тэгээд эртхэн юмны үнэ гайгүй байгаа дээр авчихсан нь зүгээр гэсэн ийм санал байна. Манай дипломатууд маань элчин Гадаад явдлын яам маань эрт дээр үеэс ер нь олон жилийн өмнөөс бол тэр их хаана сайгүй л бас газар худалдаж аваад ЭСЯ-наа тэр эдийн засгийн хүнд хэцүү нөхцөлд бол аваад ингээд байчихсан байдаг. Тэр нь одоо их тус болж байгаа.

Энэ дээр та бүхэн маань ямар бодолтой байгаа вэ?

Нөгөө талаар бас ЭСЯ-ыг байгуулаад л, буулгаад л байдаг. Би энэ дээр бол Индонез, Бразил 2-ыг хэлэх гээд байна л даа. Энэ 2 бол бүс нутагтаа хүн ам ихтэй, ер нь аягүй өргөжин тэлж байгаа, цаашидаа ч эдийн засаг нь дэвжих ийм улс орнууд. Яагаад ингээд татан буулгаад байдаг юм бэ? Алс хэт нь бол ахиад л байгуулж таарах байх. Иймэрхүү зүйлүүдийг гаргамааргүй байгаа юм гэсэн ийм 2 асуулт байна.

Б.Энх-Амгалан: Асуултад Гадаад харилцааны сайд Батцэцэг хариулъя, 3 номерын микрофоныг өгье.

Б.Батцэцэг: Ганбат гишүүний асуултад хариулъя. ЭСЯ-ны байрыг би тантай бас санал нэг байна. Ер нь бид нар үндсэн хөрөнгө худалдаж авах ийм зорилготой байгаа. Одоо бас Узбекистаны тал нэлээн идэвхтэй биднийг бас их талархалтай хүлээж аваад, энэ жилдээ манайх байгуулаад, ирэх жил зөрөөд манайд байгуулах ийм саналаа тавиад 24 онд бас өндөр дээд хэмжээний 2, 3 айлчлал хэрэгжихээр яригдаж байгаа. Тэгээд ЭСЯ-ыг ойрын хугацаанд эхний ээлжид бол түрээслэхээр ярьж байгаа, судалгаа хийгдэж байгаа. Ер нь яваандаа бол бид нар өөрийн байртай болъё гэж байгаа. Монгол Улсын төрийн тэргүүнээс бас Гадаад харилцааны сайдад үүрэг өгсөн. ЭСЯ-дуудын энэ байр байшингийн асуудлыг бол шийдэх. Одоогоор болбол бид нар 23 ЭСЯ-н дээр бол өөрийн байртай 23, бусад нь бол 49-өөс 23 нь өөрийн, бусад нь түрээснийх байдаг. Тэгэхээр энэ түрээснийхийг жилд нэг ЭСЯ-ны асуудлыг засвар хийх эсвэл үндсэн хөрөнгө худалдаж авч өөрийн байртай болох ийм чиглэлийг бол төрийн тэргүүнээс өгсөн байгаа. Энэний дагуу бид нар бас төлөвлөгөө гаргаад, судалгаа хийгээд ажиллаж байгаа.

2 дугаар асуултын хувьд бол Индонез, энэ Бразил 2-т бол ЭСЯ-аа

хаасан нь бол бас их миний хувьд бас буруу гэж үздэг. Бид нар ЭСЯ байгуулах гэж 2 улсын хооронд харилцаа тогтоосноос хойш л бараг яригддаг асуудал. Маш олон жилийн хүч хөдөлмөр, харилцааны олон зүйлүүдийг тодорхойлж байдаг. Тийм учраас ЭСЯ-ыг нэгэнт байгуулсан болбол буцаж хааж болохгүй, нээж байгуулахдаа бас маш сайн судлах ёстой гэж үздэг. Тэгээд дээр дурдсан 2 ЭСЯ-ыг эргээж сэргээж нээх талаар ажиллаж байгаа. Индонезын ЭСЯ-аа нээхээр би бас 3 сарын өмнө Индонезийн Гадаад сайд бас Монголд айлчилсан. Гадаад хэргийн хэргийн сайд нь. Дараа нь би бас хуралд очихдоо уулзаад тэгээд Индонезид ЭСЯ-аа 24 онд байгуулна гэдгээ илэрхийлээд, ирэх, энэ жилийн төсөвт суулгачихсан. Индонезийн ЭСЯ ингээд сэргээгээд нээгдэхээр болж байгаа.

Бразилын хувьд бол Бразилын тал бол бас өнгөрсөн оны сүүлээр бид нарт ЭСЯ-аа сэргээж байгуулаач гэдэг ийм саналыг тавьсан. Тэгээд бид бол нааштайгаар хүлээж аваад энийг 25 онд нээх болов уу гэж бодож байна. Төсвийг нь тэгж тавиад.

Б.Энх-Амгалан: Баярлалаа. Гишүүд асуулт асууж, хариулт авч дууслаа. Тогтоолын төсөлтэй холбогдуулан үг хэлэх гишүүн байна уу? Баттөмөр гишүүнээр тасаллаа. Нямаагийн Энхболд гишүүн үг хэлье гэж байна. Дээр нь нэмээд Амартүвшин гишүүн хэлье гэж байна. Ингээд Амартүвшин гишүүнээр тасаллаа. Баагаагийн Баттөмөр гишүүн үг хэлье.

Б.Баттөмөр: Узбекистан улсад ЭСЯ байгуулах саналыг бол дэмжиж байна. Узбекистаны хувьд болбол байрлал геополитикийн хувьд бол их зөв байрлалтай байдаг, 2 хөрштэйгөө нийлдэггүй зах хиллэдэггүй. Тэгэхдээ бас Төв Азийн гол орны нэг гэж ингээж үздэг, хөгжиж байгаа, хөгжлийн бас потенциал бол их өндөр гэж ингээж үздэг юм байна лээ. Энд бол яах вэ цомхон 3

хүний орон тоотой ингээд хийгээд явах нь зүйтэй гэдэг.

Сая тэр Ганбат гишүүний хэлж байгаа дээр би нэг санал хэлэх гээд байгаа юм даа. Тэгэхээр энэ тэр байр худалдаж авна гэдэг болбол маш чухал. Тухайлбал тэр энэ Казахстан улсын хөгжил бол бид чинь нэг гараанаас гарсан шүү дээ тийм ээ. Казахстан бол хуучин соц гэж байсан орнууд дотор их үлгэр жишээ сайн хөгжиж байна. Гадаадын хөрөнгө оруулалтыг маш их сайн татсан. Нэг хүнд ноогдох дотоодын нийт бүтээгдэхүүний хэмжээ 12 мянган доллар болчихсон байна өнөөдөр, өнгөрсөн жилийн байдлаар. Одоо ингээд энэ оных энэ тэр юу болж байгаа юм. Тэгээд тэд болбол гадаадын хөрөнгө оруулалтыг хязгаарлаж эхэлж байгаа байхгүй юу. Тухайлбал банканд болбол хөрөнгө оруулахгүй, гаднаас хөрөнгө оруулалт авахгүй. Даатгалын салбарт авахгүй гээд. Тэгээд энэ нь болбол юу гэхээр өөрсдөө энэ дээр өрсөлдөөнөө бий болгочихсон. Өөрсдөө асуудлаа шийдчихсэн байгаа. Тэгээд энд нэг хэлэх гэж байгаа зүйл бол юу гэхээр зэрэг Казахстаны Баялгийн сан гэж байна л дээ тийм ээ. Тэгээд их олон Баялгийн сан бид чинь одоо Тимосек тэгээд л нөгөө Норвегийн тэтгэврийн сан гээд л очоод л үзээд л байгаа юм. Тэгээд яг Казахстаны тэр Баялгийн санг бүрдүүлж байгаа юу бол манайд их тийм сургамжтай тийм их зөв бүрдүүлж байгаа юм л даа.

Тухайлбал энэ Казахууд уучлаарай, Казахстаны одоо, Казахстан улс Парисын төвд нэг байшин худалдаж авсан, ЭСЯ-аа оруулсан. Өнөөдөр тэрний үнэлгээ нь 3 дахин өсчихсөн явж байгаа. Ромд 8 га газартай нэг байшин худалдаж авсан, бас 2-оос 3 дахин өссөн байгаа. Тэгээд энийг болбол юу гэхээр зэрэг тэр Баялгийн сангийнхаа хөрөнгөөр бас зарим юмыг нь худалдаж аваад, Баялгийн сандаа бүртгэлтэй явдаг. Тэгээд ер нь болбол энэ Европын орнууд бусад орнуудад бол энэ ЭСЯ-дуудаа байртай болгох 1 дүгээрт, байртай

болгохоос гадна тэр чинь тэр үл хөдлөх хөрөнгө гэдгийн үнэ болбол ерөөсөө буурахгүй шүү дээ тийм ээ. Тийм учраас энэ дээр манай ГХЯ Батцэцэг сайд бас анхаарна биз дээ. Бид чинь бас нэг үеэ бодвол энэ баялаг дээр хийж байгаа зарим нүүрсэн дээр хийж байгаа менежментээс Монголын төсөв болбол ашигтай гарсан. Мөн төсвөөс гадна болбол төрийн өмчтэй байгууллагуудын үлдээж байгаа юу бол бараг 2 их наяд төгрөгийн хуримтлал бий болчихсон байна шүү дээ тийм ээ. Тэрийгээ нөгөө ард иргэддээ нөгөө 1072 хувьцаагаа, хувьцааны ноогдол ашиг өгье гээд явж байгаа юм. Ер нь бол бас энийг үзээд, хаана, хаана ямар байришилд, ямар үл хөдлөх хөрөнгө худалдаж авах вэ, байртай болгох тэр нь буцаагаад бас үнээ алддаггүй байх энэ юмыг л бас үзмээр байгаа юм даа. Би ийм санааг хэлэх гэсэн юм. Сая Ганбат гишүүн хэлсэн учраас би энэ дээр дэмжиж, энэ маш зөв зүйтэй санал шүү гэж хэлэх гэсэн юм. Баярлалаа.

Б.Энх-Амгалан: Нямаагийн Энхболд гишүүн үг хэлье. Узбекстанд ЭСЯ-аа нээж ажиллуулах, харилцан ЭСЯ-тай болж ажиллах талаар оруулж ирж байгаа саналыг дэмжиж байна. Би зүгээр яамыг, яам голдуу эхлээд санал гаргаад явах ёстой. Шинээр ЭСЯ байгуулж байгаа газарт эхний ээлжид тэр нэг аж ахуйн талын ажлууд нь хөл дээрээ босгох ажлууд нь маш их чухал байдаг юм байна лээ. Тэгэхээр энэ дээр нэлээн тийм туршилагатай, зангаргатай хүн явуулах хэрэгтэй болов уу гэж бодож байна. Зүгээр бодлоо л хэлж байгаа юм шүү. Та нар бас анхаарна биз. Урьд өмнө нь яг тэр аж ахуйн ажлыг нээх байр сав олох, юмаа төвхнүүлэх энэ юман дээр болбол ийм туршилагатай хүмүүс илүү их үр дүнтэй ажиллаж байсан практик байгаа манай яамны ажилд. Тэгэхээр энэ тал дээр бас хэзээ хүнээ явуулдаг юм байгаа юм, тэр үедээ асуудлаа бас энэ талаас нь бас нэг бодож үзээрэй л гэж зөвлөх гээд байгаа юм. Тийм.

Б.Энх-Амгалан: Ганибалын Амартүвшин гишүүн үг хэлье.

Г.Амартүвшин: Энэ Ташкент хотод ЭСЯ байгуулах асуудлыг бол дэмжиж байгаа. Ямар ч байсан Төв Азидаа бол хамгийн том эдийн засаг, 35 сая хүн амтай, 80 тэрбум долларын ДНБ-тэй, маш том хэмжээний алт болон зэс, газрын хий, нефть олборлодог, боловсруулдаг тийм том эдийн засагтай улс орон болохоор бид нар ялангуяа ЗГ-аас баримталж байгаа эдийн засгаа солонгоруулах энэ хөтөлбөрт нь нэмэртэй шинэ ЭСЯ байгуулж байна, харилцааг илүү дараагийн түвшинд гаргах тийм боломж гарна гэж би бодож байна. Ялангуяа мал, хөдөө аж ахуй, мал, малын бүтээгдэхүүнийг экспортлох тийм том суваг нээгдэнэ гэдгийг бол одоо ч гэсэн ААН-үүд хувиараа бол ийм экспорт хийж байгаа юм байна лээ. Тэгэхдээ ЭСЯ бас байгуулагдсанаар бас илүү том боломж харна гэж, гарна гэж харж байна.

2 дугаарт яг Ташкент хотод очиход яг манай 10 жилийн өмнө Улаанбаатар хотод үл хөдлөхийн зах зээл яаж өсөж байсан яг тэр хэмжээнд явж байгаа юм байна лээ. Тэгэхээр гишүүдийн яриад байгаа ЭСЯ-ныхаа байр саваа сонгохдоо бас тэрийг сайн судалж бодолцож яагаарай. Ер нь авсан нь бол хамаагүй дээр юм байна лээ. Жилээс жилд үл хөдлөх үнэ үнэлгээ нь өсөж байгаа тийм хот юм байна лээ л дээ. Тийм болохоор энэ дээр бас Гадаад яамныхан анхаарна биз дээ. Тэгээд цаашдаа болохоор шууд нислэг болон харилцан аялал жуулчлалын урсгалыг дэмжих тал дээр бол Гадаадын яам болон аялал жуулчлал, Байгаль орчны яам хамтарч ажиллаад энийг илүү хөгжүүлэх боломжийг нь гаргана биз дээ гэж бодож байна.

Б.Энх-Амгалан: Баярлалаа. Гишүүдийн хэлж байгаа саналуудыг бас цаашдын ажилдаа Гадаад харилцааны яамныхан маань тусгаад ажиллаарай. Узбекистан улсад болбол ЭСЯ-а нээн

ажиллуулах бол нэн чухал хэрэгцээтэй. Турк улс, Турк, Азербайжан, Казахстан, Монгол гэсэн дунд коридор, Турк, Азербайжан, Казахстан, Пакистан, Зүүн Өмнөд Ази гэсэн 2 дахь коридор, тэгээд Дундад Ази руу чиглэсэн энэ Узбекистан, Киргиз, тэгээд Эстони, Армен гэж чиглэсэн энэ чиглэлүүд дээр бол бид нар бас нэлээн худалдааны манай бас бүс байж мэдэх ийм нэлээн онцлогууд байгаа. Эхний ээлжид ЭСЯ маань нээн ажиллуулж байгаад яах вэ 3 орон тоотой энэ 2024 оны төсөвт зардал нь суусан юм байна. Тэгээд үйл ажиллагаа нь жоохон өргөжсөөд ирвэл нэмэх тал дээр нь анхаарна биз дээ. Тэгээд та бүхэнд амжилт хүсье. Асуудлыг бол дэмжиж байгаа. Ингээд гишүүд асуулт асууж, хариулт авч, үг хэлж дууслаа.

Санал хураана. Бүгд найрамдах Узбекистан улсын нийслэл Ташкент хотод Монгол Улсын Элчин сайдын яам нээн ажиллуулах тухай Монгол Улсын Их Хурлын тогтоолын төслийг дэмжье гэсэн томьёолоор санал хураалт явуулъя. Санал хураалт гишүүдээ. Санал хураалтын дүнг танилцуулъя. 12 гишүүн оролцсоноос 7 гишүүн дэмжлээ. Хэн Наранбаатар гишүүний төхөөрөмж ажиллаагүй байна. Протоколд тэмдэглээд, дэмжсэнээр оруулаарай. Ингээд уг тогтоолын төслийг дэмжсэн талаарх Байнгын хорооны санал, дүгнэлтийг чуулганы нэгдсэн хуралдаанд Улсын Их Хурлын гишүүн Баделхан гишүүн танилцуулах уу? Танилцуулъя.

12.56 цаг

Байнгын хорооны өнөөдрийн хуралдаанаар хэлэлцэх асуудал дууссан тул хуралдаан өндөрлөснийг мэдэгдье. Хуралдаанд идэвхтэй оролцсон Улсын Их Хурлын гишүүд, ажлын хэсгийнхэнд баярлалаа. Хуралдаан өндөрлөлөө.

ДУУНЫ БИЧЛЭГЭЭС ХУРАЛДААНЫ
ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ
БУУЛГАЖ, ХЯНАСАН:
ШИНЖЭЭЧ Д.УЯНГА